



**МОНГОЛ УЛС ДАХЬ ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ
ОРЧИН ҮЕИЙН ЭМ, ХЭРЭГСЭЛ, ЭХ БАРИХЫН БА
НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАЙЛШГҮЙ
ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН
ХҮРТЭЭМЖИЙН СУДАЛГАА**

**Улаанбаатар
2015**

Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан, Эрүүл мэнд, спортын яамны хамтарсан захиалгаар гүйцэтгэсэн “Монгол улс дахь жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгсэл, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийн судалгаа”, “Гэр бүл төлөвлөлтийн чанарын судалгаа”, “Монгол улс дахь гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээний нөхцөл байдлын дүн шинжилгээ” гэсэн гурван судалгааны дүнг танилцуулахад нэн таатай байна. Эдгээр судалгаа нь сүүлийн хоёр жилд хийгдсэн бие даасан судалгаа хэдий ч гэр бүл төлөвлөлтийн тулгамдсан асуудлуудыг олон талаас, бүхлээр нь шинжлэх бололцоо олгох үүднээс нэгтгэн багцалсан юм.

Гэр бүл төлөвлөлт нь хүний эрх ба нийгмийн хөгжлийн нэгэн цөм хэсэг бөгөөд эх, хүүхдийн эрүүлийг хамгаалах хамгийн үр дүнтэй интервенцийн нэг юм. Сүүлийн хорин жилийн хугацаанд Монгол улс эх, хүүдийн эндэгдлийг бууруулахад гайхалтай амжилт гаргасан. Гэхдээ жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн чанар, хүртээмжийн талаар сэтгэл ханамжтай нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо буурсаар байгаа нь ялангуяа охид, залуу эмэгтэйчүүд үр хөндүүлэх, бэлгийн замаар дамжих халдвар авах явдлыг нэмэгдүүлж байна. Иймээс бэлгийн болон нөхөн үржихүйн тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээг нэн даруй, ялангуяа залуу эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн дунд авах шаардлагатай болжээ.

“Монгол улс дахь гэр бүл төлөвлөлтийн тусламж үйлчилгээний нөхцөл байдлын дүн шинжилгээ” нь Монгол улс эх, хүүхдийн эрүүл мэндийн тусламжийг маш сайн хөгжүүлсэн хэдий ч гэр бүл төлөвлөлтийн тусламжаа орхигдуулсан байдлыг илтгэж байна. Эрүүл мэндийн бүх гурван шатлалд гэр бүл төлөвлөлтийг өргөнөөр, нээлттэйгээр сурталчилдаггүй, тулсамжийн чанар хангалтгүй байна. Гэр бүл төлөвлөлтийн тусламжийг сайжруулахад хангамжийн асуудал дээр улсаас хангалттай хөрөнгө нөөц дайчлахгүй байгаа нь бэрхшээлийг нэмэгдүүлж байна.

“Монгол улс дахь жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгсэл, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийн судалгаа” нь жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм хэрэгслийн тасалдал эрс өссөнийг харууллаа. Хэрвээ 2013 онд сүүлийн 6 сарын хугацаанд жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгсэл тасалдаж байгаагүй эрүүл мэндийн багууллагын хувь хөдөө орон нутагт 79, нийслэлд 39% байсан бол, 2015 онд тэдгээрийн эзлэх хувь орон нутагт 10.8, нийслэлд тэг болж буурсан байлаа. Эм хэрэгслийн хангамж өсвөр үеийнхэн, залуучуудад ээлтэй клиникт мөн хомс байгаа нь охид, хөвгүүдийг бэлгийн замаар дамжих халдвар, хүсээгүй жирэмслэлтээс сэргийлэх боломжийг бууруулж байна.

“Гэр бүл төлөвлөлтийн чанарын судалгаа” нь охид, эмэгтэйчүүдийн дунд жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн талаар

маш их ташаа ойлголт байдаг, одоогийн эрүүл мэндийн тусламжийн хүрээнд үнэн зөв мэдээлэл тархаах, зөвлөгөө өгөх, хянах асуудал нь орхигдсоныг харууллаа. Дээрхи судалгааны дүнгээс харахад гэр бүл төлөвлөлтийн тусламжийг эрс сайжруулах хэрэгцээ харагдаж байна. Үүний тулд жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийг худалдан авах засгийн газрын төсвийг нэмэгдүүлэх, эмч мэргэжилтний, ялангуяа эх баригч нарын ур чадварыг олон улсын жишигт хүртэл сайжруулах шаардлагатай.

Би бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч нарыг мөн үндэсний болон олон улсын түнш байгууллагуудыг энэ гурван судалгааны дүнг ашиглан Монгол улсад гэр бүл төлөвлөлтийн тусламжийг сайжруулахад ээлтэй орчин бүрдүүлэхийн төлөө ажиллахыг уриалж байна. Жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн хүртээмжтэй байдал нь Монголд жирэмслэлт бүр хүссэн, төрөлт бүр эсэн мэнд байж, залуу хүн бүр нөөц бололцоогоо бүрэн дайчилж, хөгжлийн өндөрлөгт хүрэх нөхцөлийг бүрдүүлэхэд нэн чухал юм.

Наоми Китахара, НҮБ-ын Хүн амын сангийн Суурин төлөөлөгч

ТАЛАРХАЛ

Юуны өмнө судалгааны багийн өмнөөс нийт аймаг, хотын эрүүл мэндийн газар, нэгдэл, сум, ӨЭМТ-ийн удирдлага, хамт олонд энэхүү судалгааг амжилттай гүйцэтгэх нөхцлийг бүрдүүлэн, чин сэтгэлээсээ тусалж, хамтран ажилласанд гүн талархаж байна.

Аймаг, сум, дүүргийн эмнэлэгт эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эмч, эх баригч, сувилагч, эмийн хангамжийн байгууллагын ажилтны ажил хэрэгч, чин сэтгэлийн тусламж, дэмжлэгийн ачаар энэ судалгааг амжилттай гүйцэтгэсэн гэдгийг зориуд тэмдэглэж байна. Мөн орон нутагт мэдээлэл цуглуулах ажилтанг томилж, шаардлагын дагуу томилолт гарган өгсөн бүх шатны эмнэлгийн байгууллагын удирдлагуудад талархлаа илэрхийлье.

Уг судалгаа нь Монгол улс дах НҮБ-ын ХАС-гийн санхүүжилт, арга зүйн дэмжлэгтэйгээр хийгдсэн болно. НҮБ-ын ХАС-гийн суурин төлөөлөгчийн газрын ажилтнуудын дэмжлэг туслалцаатайгаар энэхүү судалгааны ажлыг амжилттай гүйцэтгэсэн гэдгийг зориуд тэмдэглэн, гүн талархлаа илэрхийлье.

Судалгааны баг

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АНЭ	Аймгийн нэгдсэн эмнэлэг
БЗДХ	Бэлгийн замаар дамжих халдвар
БОЭТ	Бүсийн оношлогоо, эмчилгээний төв
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДНЭ	Дүүргийн нэгдсэн эмнэлэг
ДОХ	Дархлалын олдмол хомсдол
ЖСАХ	Жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл
МХЗ	Мянганы хөгжлийн зорилтууд
НҮБ-ын ХАС	Нэгдсэн үндэстний байгууллагын Хүн амын сан
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
НҮЭМЭХТХ	Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тасалдалгүй хангамж
НЭ	Нэгдсэн эмнэлэг
СЭМТ	Сумын Эрүүл Мэндийн Төв
ӨЭМТ	Өрхийн Эрүүл Мэнд Төв
ТББ	Төрийн бус байгууллага
ҮҮН	Үйлчилгээ үзүүлэгч нэгж
ХДХВ	Хүний дархлал хомсдолын вирүс
ЭХЭМҮТ	Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

ӨМНӨХ ҮГ	ii
ТАЛАРХАЛ	iv
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	v
АГУУЛГА	vi
ЗУРАГ, ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	viii
ТОВЧ ДҮГНЭЛТ.....	x
БҮЛЭГ I. ТАНИЛЦУУЛГА	2
1.1 Судалгааны үндэслэл, зорилго	2
1.2 Мэдээлэл цуглуулагчдын сургалт	4
1.3 Мэдээлэл цуглуулалт	4
1.4 Мэдээллийн дүн шинжилгээ, үр дүнгийн танилцуулга	4
БҮЛЭГ II. НҮЭМ-ИЙН ТАЛААР ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД МӨРДӨГДӨЖ БҮЙ ХӨТӨЛБӨР, УДИРДАМЖ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БҮЙ БАЙГУУЛЛАГА	6
2.1 ЖСАХ-ийн удирдамж	6
2.2 Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай эмийн удирдамж	7
2.3 Монгол улсад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй байгууллага	7
БҮЛЭГ III. ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН	8
3.1 Судалгаанд хамрагдсан ҮҮН-ийн танилцуулга	8
3.1.1 ҮҮН-ийн газарзүйн байршил	8
3.1.2 ҮҮН-ийн төрөл, шатлал	9
3.1.3 ҮҮН ба эм, хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага хоорондын зай	10
3.2 ҮҮН-ийн ЖС, орчин үеийн арга хэрэгслийн хангамж	10
3.2.1 Гурав ба түүнээс дээш төрлийн орчин үеийн ЖСАХ-ээр үйлчилж байгаа ҮҮН	10
3.2.2 Таван төрлийн ЖС орчин үеийн эм, хэрэгслээр үйлчилгээ үзүүлж буй анхан шатны ҮҮН	13
3.2.3 Үндэсний удирдамжийн дагуу эр бэлгэвч, уух эм, тариагаар үйлчилгээ үзүүлж буй ӨЭМТ	15
3.2.4 Үндэсний удирдамжийн дагуу эр бэлгэвч, уух эм, тариа, ерөндгөөр үйлчилж буй СЭМТ	16
3.2.5 Судалгаа хийх үед ЖС орчин үеийн аргаар үйлчлэхгүй байсан шалтгаан	18
3.3 Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж	18
3.3.1 Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамж	21
3.3.2 Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн тасарсан байдал	22
3.4 Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж	23
3.4.1 Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн тасарсан шалтгаан	25
3.5 Эх барихын ба НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай зарим хэрэгслийн хангамж	26

3.5.1	Эх барихын ба НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай зарим хэрэгсэл тасарсан шалтгаан	27
3.5.2	ҮҮН-ийн ЖС орчин үеийн арга, хэрэгслийн нөөц сүүлийн 6 сард тасарсан байдал	28
3.5.3	ҮҮН-ийн ЖС орчин үеийн арга, хэрэгслийн нөөц сүүлийн 6 сард тасарсан шалтгаан	30
3.6	ҮҮН-ийн хангамжийн тогтолцоо	30
3.6.1	ҮҮН-ийн хүйтэн хадгалах системийн байдал	32
3.6.2	ҮҮН-ийн НҮЭМ-ийн удирдамж, протокол ашиглалт	33
3.6.3	ҮҮН-ийн интернет, мэдээлэл технологийг ашигладаг байдал	35
3.6.4	ҮҮН-ийн үйлчилгээний төлбөр	36
3.6.5	Эмнэлэгийн хог хаягдал, устгал	36
3.7	Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа	37
	БҮЛЭГ.IV ДҮГНЭЛТ	42
4.1	Гол үр дүнгээс гарсан дүгнэлт	42
4.2	Судалгаанаас гарсан санал, зөвлөмж	44
	АШИГЛАСАН МАТЕРИАЛ	46
	ХАВСРАЛТ 1. Судалгааны хүн ам, түүвэрлэлт	47
	ХАВСРАЛТ 2. Судалгааны асуумж	54
	ХАВСРАЛТ 3. Судалгааг гүйцэтгэсэн ажлын хэсгийн бүрэлдэхүүн	74
	ХАВСРАЛТ 4. Аймаг дүүргийн ҮҮН-ийн нэрс	75
	ХАВСРАЛТ 5. ЖСАХ-ийн үр дүнгийн харьцуулсан үзүүлэлт	73
	ХАВСРАЛТ 6 Үнэлгээг хийх үед судлаачдын уулзаж, мэдээлэл авсан авсанэмч, ажилчдын нэрсийн жагсаалт	89

Хүснэгт 1.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгслээр хангах үндэсний удирдамж	7
Хүснэгт 2.	Судалгаанд хамрагдсан ҮҮН,бүс нутаг, эмнэлгийн төрлөөр	9
Хүснэгт 3.	Үнэлгээнд хамрагдсан ҮҮН-ээс НҮЭМ-ийн эм, хэрэгсэл нийлүүлэх байгууллага хүртэлх зай (км-ээр)	10
Хүснэгт 4.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслийн хангамжийн хувь ҮҮН-ийн шатлалаар	11
Хүснэгт 5.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж байгаа хувь,бүсчлэлээр	11
Хүснэгт 6.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж байгаа хувь,ҮҮН-ийн байршлаар	12
Хүснэгт 7.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслийн хангамжийн хувь, (ҮҮН-ээс хангамжийн газар хүртэлх зайгаар)	12
Хүснэгт 8.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж байгаа хувь, (Шатлал,хангамжийн газар хүртэлх зайгаар)	13
Хүснэгт 9.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж байгаа анхан шатны ҮҮН-ийн хувь, газарзүйн бүсээр	14
Хүснэгт 10.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж байгаа анхан шатны ҮҮН-ийн хувь,ҮҮН-ийн байршлаар	14
Хүснэгт 11.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж байгаа анхан шатны ҮҮН-ийн хувь, ҮҮН-ээс эм ханган нийлүүлэх хангамжийн газар хүртэлх зайгаар	15
Хүснэгт 12.	Эр бэлгэвч, уух эм ба тариагаар үйлчилдэгӨЭМТ-ийн хувь	15
Хүснэгт 13.	Орчин үеийн таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилдэг ӨЭМТ-ийн хувь.	16
Хүснэгт 14.	Эр бэлгэвч, уух эм, тариа, ерөндөгөөр үйлчилдэг СЭМТ-ийн хувь	17
Хүснэгт 15.	Орчин үеийн таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилдэг СЭМТ-ийн хувь	17
Хүснэгт 16.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгсэл тасарсан шалтгаан	18
Хүснэгт 17.	Эхбарихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж	20
Хүснэгт 18.	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн (хоёр чухал) эмийн хангамж, байгууллагын төрлөөр	21
Хүснэгт 19.	Эх барихын ба НҮЭМ-ийн долоон төрлийн (хоёр чухал) эмийн хангамж, бүсчлэлээр	21
Хүснэгт 20.	Эх барихын ба НҮЭМ-ийнзайлшгүы шаардлагатай долоон төрлийн (хоёр чухал) эмийн хангамж, хот хөдөөгөөр	22
Хүснэгт 21.	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн (хоёр чухал) эмийн хангамж,алслагдсан зайгаар	22
Хүснэгт 22.	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамж тасарсан шалтгаан, хувиар	23
Хүснэгт 23.	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж	25
Хүснэгт 24.	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж тасарсан шалтгаан	26
Хүснэгт 25.	Эх барихын ба НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай зарим хэрэгслийн хангамж	27
Хүснэгт 26.	Эх барихын ба НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай зарим хэрэгслийн тасарсан шалтгаан	28

Хүснэгт 27.	Өнгөрсөн 6 сард ЖСАХ-ийн тасарсан байдал, ҮҮН-ийн шатлалаар	29
Хүснэгт 28.	Сүүлийн 6 сард ЖСАХ-ийн тасарсан байдал, ҮҮН-ийн бүс нутгаар	29
Хүснэгт 29.	Сүүлийн 6 сард ЖСАХ-ийн тасарсан байдал, ҮҮН-ийн байршлаар	30
Хүснэгт 30.	ҮҮН-д сүүлийн 6 сарын байдлаар ЖСАХ тасарсан шалтгаан	30
Хүснэгт 31.	ҮҮН-ийн эмийн хангамжийн тогтолцооны байдал	31
Хүснэгт 32.	ҮҮН-ийн хүйтэн хадгалах системийн байдал	32
Хүснэгт 33.	Судалгаанд хамрагдсан ҮҮН-ийн эмч, ажилчдын гэр бүл төлөвлөлтийн сургалтанд хамрагдсан байдал	32
Хүснэгт 34.	ҮҮН-ийн НҮЭМ-ийн үйлчилгээ үзүүлэгч нарын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийсэн байдал	33
Хүснэгт 35.	ҮҮН-ийн НҮЭМ-ийн удирдамж, протокол ашиглалт	34
Хүснэгт 36.	ҮҮН-ийн НҮЭМ-ийн удирдамж, протокол ашиглалт (хот, хөдөөгөөр)	34
Хүснэгт 37.	ҮҮН-ийн интернет, мэдээлэл технологийг ашигладаг байдал	35
Хүснэгт 38.	ҮҮН үйлчлүүлэгчээс төлбөр авч байгаа байдал (шатлалаар)	36
Хүснэгт 39.	ҮҮН үйлчлүүлэгчээс төлбөр авч байгаа байдал (хот, хөдөөгөөр)	36
Хүснэгт 40.	ҮҮН-ийн эмнэлгийн хог, хаягдал устгалын байдал (шатлалаар)	37
Хүснэгт 41.	ҮҮН-ийн эмнэлгийн хог, хаягдал устгалын байдал (хот, хөдөөгөөр)	37
Хүснэгт 42.	Үйлчлүүлэгчдийн талаарх ерөнхий мэдээлэл (шатлалаар)	38
Хүснэгт 43.	ҮҮН-ээс гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн байдал	39
Хүснэгт 44.	ҮҮН-ээс гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээ авахад үйлчлүүлэгчээс гарах зардал	40
Хүснэгт 45.	Гэр бүл төлөвлөлт ба төрөх үеийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бүх ҮҮН-ийн тоо (Засаг захиргааны нэгж, бүсчлэлээр)	48
Хүснэгт 46.	ҮҮН-ийн шатлалын харьцангуй хувь	49
Хүснэгт 47.	Түүвэрлэлт хийхэд шатлал тус бүрийн эмнэлгээс сонгогдсон ҮҮН-ийн тоо	49
Хүснэгт 48.	Шатлал тус бүрийн эмнэлгээс сонгогдсон ҮҮН-ийн тоо	50
Хүснэгт 49.	ҮҮН-ийн шатлалын эзлэх хувь, бүсийн байдлаар	51
Хүснэгт 50.	Шатлал тус бүрээс сонгогдсон ҮҮН-ийн тоо, бүсээр	52
Хүснэгт 51.	Хувийн эмнэлгийн орчин үеийн ЖСАХ-ийн хангамжийн хувь	71
Хүснэгт 52.	Өсвөр үеийн кабинетийн орчин үеийн ЖСАХ-ийн хангамжийн хувь	71
Хүснэгт 53.	Хувийн эмнэлгийн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслийн хангамжийн хувь	72
Хүснэгт 54.	Өсвөр үеийн кабинетийн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслийн хангамжийн хувь	72
Хүснэгт 55.	Хувийн эмнэлгийн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслийн хангамжийн хувь	73
Хүснэгт 56.	Өсвөр үеийн кабинетийн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслийн хангамжийн хувь	73

ЗҮРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1.	Үнэлгээнд хамрагдсан ҮҮН-ийн тоо, бүсчлэлээр	8
Зураг 2.	Судалгаанд хамрагдсан ҮҮН-ийн төрөл (хувиар)	9
Зураг 3.	ҮҮН дэх эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж	19
Зураг 4.	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж	24
Зураг 5.	Үнэлгээнд хамрагдсан ҮҮН-ийн ЖСАХ сүүлийн 6 сард тасарсан байдал	28
Зураг 6.	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурваас доошгүй төрлийн эм, хэрэгслээр хангагдсан байдал (үнэлгээний оноор)	42
Зураг 7.	Сүүлийн 6 сард орчин үеийн ЖСАХ тасалдсан байдал (үнэлгээний оноор) ..	43
Зураг 8.	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамж (үнэлгээний оноор)	44

СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

Эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг нэгж (ҮҮН) дэх орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх арга (ЖСАХ), эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийг хүртээмжтэй байлгах нь анхан шатны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг хангах нэн чухал үзүүлэлт төдийгүй эхийн эндэгдлийг бууруулахад чиглэсэн зохистой стратегийн арга хэмжээг төлөвлөх, боловсруулахад зайлшгүй харгалзан үзвэл зохих асуудлын нэг юм.

“Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тасалдалгүй хангамж”-ийн төсөл нь НҮБ-ын Хүн амын сангийн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тасралтгүй хангалтыг өргөжүүлэх дэлхий дахины хөтөлбөр”-ийн хүрээнд 2008 оноос Монгол улсад хэрэгжиж эхэлсэн. Тухайн улс, бүс ба дэлхий нийтийн түвшинд уг хөтөлбөрийн хэрэгжилтийг стандарт, загварчлагдсан “хяналт-үнэлгээ”-ний үзүүлэлтээр үнэлдэг ба уг төслийн үнэлгээг манай оронд 2011, 2012, 2013 онуудад гүйцэтгэсэн. 2014 оноос НҮБ-ын Хүн амын сан ЖСАХ-д зориулсан санхүүжилтээ зогсоосон ба Монгол улсын Засгийн газраас үнэгүй хангаж эхэлсэн. Иймд 2015 онд орчин үеийн ЖСАХ, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг ҮҮН-д үнэлэх, өмнөх онуудтай харьцуулан дүгнэх шаардлага тулгарч байна.

Энэхүү судалгааны гол зорилго нь эрүүл мэндийн ҮҮН дэх орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх арга, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг олон улсын стандарт “хяналт-үнэлгээ”-ний дагуу үнэлэхэд оршиж байлаа. Судалгааны зорилгыг биелүүлэхэд доорх зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- а) Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурваас доошгүй төрлийн аргаар үйлчилгээ үзүүлж буй ҮҮН-ийн хувь;
- б) Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таваас доошгүй төрлийн аргаар үйлчилгээ үзүүлж буй анхан шатны ҮҮН-ийн хувь;
- в) Сүүлийн 6 сарын хугацаанд орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэл тасарсан ҮҮН-ийн хувь;
- г) НҮБ-ын ХАС-гийн “Хяналт-үнэлгээ”-ний үзүүлэлтэд заасан зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад багтсан эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмээр тусламж үзүүлж буй ҮҮН-ийн хувь;

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

Үнэлгээг НҮБ-ын ХАС-гийн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тасралтгүй хангалтыг өргөжүүлэх дэлхий дахины хөтөлбөр” хэрэгжүүлж байгаа улс оронд стандарт аргачлалаар нэг агшны, дүрслэх загвараар гүйцэтгэдэг. Судалгаанд Монгол улсад эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй ҮҮН-ийг бүрэн төлөөлөхүйц түүврийг хамруулсан ба үйлчилгээ үзүүлэх шатлалыг

- а) Анхан шатны тусламжийн ҮҮН,
- б) Хоёр дах шатлалын тусламжийн ҮҮН,
- в) Гурав дах шатлалын тусламжийн ҮҮН,
- г) Төрийн бус байгууллагын харьяа ҮҮН хэмээн ангилсан. Судалгаанд хамрагдсан ҮҮН-ийн байрлаж байгаа бүс нутгаар нь засаг захиргааны албан ёсны ангиллын дагуу (Баруун бүс, Хангайн бүс, Төвийн бүс, Зүүн бүс, Улаанбаатар хот), мөн ҮҮН-ийн байрлалаас нь хамаарч Улаанбаатар хот, бусад орон нутагт байрладаг гэж тус тус ангилсан.

“Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тасралтгүй хангалтыг өргөжүүлэх дэлхий дахины хөтөлбөр”-өөс боловсруулсан жишиг асуумжийг өөрийн орны нөхцөлд тохируулан өөрчлөн найруулж, мэдээллийг цуглуулсан. Мэдээллийн боловсруулалтыг “R 3.1.3” программ ашиглан, хөтөлбөрөөс гаргасан стандарт хүснэгтийг ашиглан, дүрслэх статистикаар гүйцэтгэлээ. Тодорхой хувьсагчуудын уялдааг шаардлагатай статистик шалгуураар шалгав.

ГОЛ ҮР ДҮН

Орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн хангамж ба тасалдал

2015 оны үнэлгээнд нийт 205 ҮҮН-ийг хамруулснаас анхан шатны 161, хоёр дах шатлалын 38, гурав дах шатлалын 6 ҮҮН байлаа. Анхан шатны ҮҮН-ийн 71.4%, хоёрдогч шатлалын 71.1% нь орчин үеийн багадаа гурван төрлийн ЖСАХ-ээр үйлчилгээ үзүүлж байсан бол гурав дах шатлалын 83.3%-д тус үйлчилгээг үзүүлсэн дүн гарчээ. Орчин үеийн таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилгээ үзүүлж байгаа анхан шатны ҮҮН-ийн 30.4% нь дээрх үйлчилгээг үзүүлж байна.

Судалгаанд баруун бүсээс 33, хангайн бүсээс 42, төвийн бүсээс 40, зүүн бүсээс 20, Улаанбаатар хотоос нийт 70 ҮҮН тус тус хамрагджээ. Орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх гурван төрлийн аргаар үйлчилгээ үзүүлж буй ҮҮН баруун бүсэд 81.8%, хангайн бүсэд 66.7%, төвийн бүсэд (85.0%, зүүн бүсэд 70.0% тус тус байсан бол Улаанбаатар хотын ҮҮН-ийн 62.9% нь үйлчилгээ үзүүлж байна.

Таваас доошгүй төрлийн ЖСАХ-ээр үйлчилж байсан анхан шатны ҮҮН баруун бүсэд хамгийн өндөр хангамжтай буюу 57.7% байсан бол хангайн бүс 40.0%, төвийн бүс 38.7%, зүүн бүс 31.2% байсан бол хамгийн бага хангамжтай нь Улаанбаатар хот 5.7% байв. Таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилдэг ӨЭМТ-ийн хувь 14.1% байв. Таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилдэг СЭМТ 49.3% байв.

Төрийн өмчит ҮҮН-ийн 73.5%, ТББ-ын эмнэлгийн 33.3% нь орчин үеийн гурван төрлийн ЖСАХ-ээр үйлчилгээ үзүүлж байсан бол төрийн өмчит ҮҮН-ийн 30.4%,

төрийн бус байгууллагын эмнэлгийн 33.3% нь орчин үеийн таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилжээ.

Үнэлгээнд хамрагдсан ӨЭМТ-ийн 70.6% нь үндэсний удирдамжийн дагуу эрэгтэй бэлгэвч, уух эм, тариагаар үйлчилж байсан бол төрийн бус байгууллагын эмнэлгийн 33.3% нь ижил хангамжтай гарчээ. СЭМТ нь үндэсний удирдамжийн дагуу эр бэлгэвч, уух эм, тариа ба ерөндгөөр үйлчлэх ёстой. Үнэлгээнд хамрагдсан СЭМТ-ийн 73.2% удирдамжийн дагуу ажилласан байна. Бүсийн байдлаар судлахад нийлүүлэлт хангайн бүсэд сул (57.1%) боловч бусад бүстэй (75.5-82.4%) харьцуулахад ялгаа бага ($p>0.05$) ажиглагдлаа. СЭМТ-өөс эм, хэрэгсэл нийлүүлэх байгууллага хүртэлх зайнаас ЖСАХ-ийн хангамж хамаарч, 49 км хүртэл зайнд хангамж харьцангуй илүү буюу 81.2% байсал бол 100 км ба түүнээс дээш зайнд хангамж 70.6% хүрч буурчээ ($p<0.01$).

Сүүлийн 6 сард ҮҮН-ийн 93.1%-д аль нэг төрлийн ЖСАХ дор хаяж нэг өдрөөр тасарсандүн гарчээ. Орчин үеийн ЖСАХ-ийн тасарсан шалтгааны хамгийн өндөр хувийг “Хангамжаас шалтгаалсан” байдал эзэлжээ. Үүнд: Эр бэлгэвчийн 95.2%, эм бэлгэвчийн 62.1%, уух эмийн 91.3%, тарианы 91.3%, ерөндгийн 66.7%, яаралтай уух эмийн 87.1% нь хангамжийн байгууллагаас болж тус тус тасалдсан байна. “ҮҮН-ээс шалтгаалж тасарсан” тохиолдол харьцангуй бага зөвхөн эм бэлгэвч тасарсан тохиолдлын 7.4%, уух эмийн 6.7%, яаралтай уух эмийн 4.8% болон суулгацын 5.0%-д ҮҮН-ээс шалтгаалан тасарсан гэж хариулсан. Үнэлгээний үед орчин үеийн ЖСАХ тасарсан дараах шалтгаанд “зах зээлд байхгүй” гэсэн шалтгаанаар эмэгтэй бэлгэвч, тариа ба яаралтай уух эм тасарсан байв.

Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамж, тасалдал

Судалгаанд хамрагдсан төрөх үеийн тусламж үйлчилгээ үзүүлдэг бүх ҮҮН-үүд Магни сульфат (100.0%), Окситоцин (100.0%) гэсэн зайлшгүй шаардлагатай 2 эмээр бүрэн хангагдсан байлаа. Халдварын эсрэг эмийн хувьд Ампициллин (95.1%), Гентамицин (92.2%), Метронидазол

(84.3%)-оор дийлэнх ҮҮН хангагдсан байсан боловч Цефазолины бүлгийн эм (62.7%), Бензатин пенициллин (53.5%), Азитромицин (13.7%)-ы хангамж муу байв. Даралт бууруулах эмийн хангамж харилцан адилгүй буюу Нифедипин 84.5%, Гидралазин 62.1%, Метилдопа 39.8% - иар хангагджээ. Умайн булчин агшаах эмийн хувьд Мизопростол 41.4% байсан бол Мифепристон (22.2%)-ийн хангамж харьцангуй доогуур байв.

Уг судалгааг гүйцэтгэх үед эх барихын зайлшгүй шаардлагатай хоёр эм болох Окситоцин, Магни сульфат болон бусад нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээнд өргөн хэрэглэдэг халдварын эсрэг, даралт бууруулах, умайн булчин агшаах, судсаар хийх шингэн зэрэг таван төрөл, нийт долоон төрлийн эмийн хангамж хоёр дах шатлалын эмнэлэгт маш сайн (100.0%) байсан бол гурав дах шатлалын эмнэлгийн хувьд 83.3%, анхан шатны эмнэлгийн 84.5% нь дээрх эмийн бэлдмэлийг нөөцөлсөн байв. Бүсчлэлийн хувьд нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж зүүн бүс, Улаанбаатар хотын ҮҮН-үүдэд 100.0%, хангайн бүсэд 92.9% байсан бол баруун (83.3%) болон төвийн бүсэд (80.0%) харьцангуй бага байв. ҮҮН-ийн хангамжийн байгууллагаас алслагдсан байдал нь эмийн хүртээмжид хэрхэн нөлөөлж байгааг авч үзэхэд 100 км болон түүнээс дээш байрлалтай ҮҮН-д 91.7% байсан бол 50 км хүртэл байрлалд 85.7%, 50-99 км-т 81.8% ийн хангамжтай ($p < 0.05$) буюу дээрх эмийг нөөцөндөө байлгаж үйлчилгээ үзүүлжээ.

Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн тасалдал улсын хэмжээнд 11.7% байгаа ба хангамж үндсэндээ хангамжийн байгууллага болон ҮҮН-ээс тэнцүүхэн шалтгаалж тасарсан үзүүлэлт гарсан. Дээрх байдлаас дүгнэн үзэхэд ҮҮН дэх ЖСАХ, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжид эрүүл мэндийн нэгжийн хэлбэр, тэдгээрийн байршил, бүс ба алслалт гэх мэт хүчин зүйлс тодорхой хэмжээгээр нөлөөлж байна.

СУДАЛГААНААС ГАРСАН ЗӨВЛӨМЖ

Эрүүл мэндийн салбарын ба байгууллагын шийдвэр гаргагч нар

- Засгийн газар, Эрүүл мэнд, спортын яамнаас орчин үеийн ЖСАХ, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндэд зайлшгүй шаардлагатай эмийн тогтвортой хангамжийг сайжруулах зорилгоор худалдан авалтын хэмжээг эрс нэмэгдүүлэх, ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулах.
- Эрүүл мэндийн байгууллагын шийдвэр гаргагчид нь аливаа судалгааны дүнд дүгнэлт хийж, доголдож байгаа үзүүлэлтүүдийг түлхүү анхаарч, нөөцөө төвлөрүүлэн тогтмол хяналт тавьж ажиллах шаардлагатай. Ингэснээр ҮҮН дэх орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх арга, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг тогтвортой байлгахад эерэгээр нөлөөлөхөд ихээхэн чухал үүрэгтэйг анхааран, цаашдын үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тусган ажиллах.
- Хяналт үнэлгээний цахим тогтолцоог бүрдүүлэх
- Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм хэрэгсэл, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмээр хүртээмжтэй тогтвортой хангахын тулд ҮҮН бүрт нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж хариуцах эмч мэргэжилтэнг (СЭМТ, ӨЭМТ, Нэгдсэн эмнэлэг, Эрүүл мэндийн газар гэх мэтээр) албан ёсоор тодорхойлж, баталгаажуулах, Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн нэгдэл, Нэгдсэн эмнэлгийн дарга, шийдвэр гаргагч нарыг ЖСАХ, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж удирдлагын сургалтанд хамруулж, тогтвортой дэмжлэгт удирдлагаар хангах явдал нэн чухал байна.
- Эм, хэрэгслийн хангамжийн асуудлыг хариуцсан ажилтнуудыг шинээр болон давтан сургалтанд хамруулан, тэднийг чадавхижуулах, төлөвлөгөөтэй, тусгайлсан дэмжлэгт хяналтыг ҮҮН-үүдэд тогтмол хийж байх,
- ЖСАХ, орчин үеийн эм хэрэгсэл, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл

мэндийн эмийн хангалт Улаанбаатар хотын ҮҮН-үүдэд олон хүнд, үйлчилдэг, ҮҮН олонтойг бодолцон хэрэгцээнд тулгуурлан илүү хуваарилж байх,

- Ерөндөг, суулгац зэрэг тодорхой стандарт орчин шаарддаг орчин үеийн ЖСАХ-ийг хоёр, гурав дах шатлалын бүх эмнэлэгт хүрэлцээтэй нөөцөлж үйлчлэх.
- Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамж харьцангуй тогтвортой байгаа хэдий ч буурах хандлагатай байгааг анхаарч цаашдын тасралтгүй хангалтанд бүх шатандаа анхаарах
- Орчин үеийн ЖСАХ-ийг зах зээлд чөлөөтэй зарж, борлуулах нь хангамжийн байдалд эерэгээр нөлөөлөхийг анхаарч, эрэлтэнд нийцүүлэх
- Орон нутгийн ба бүс нутгийн удирдлагууд, эрүүл мэндийн байгууллага, олон нийтэд ухуулга нөлөөллийн ажлыг цогцоор зохион байгуулахад мэргэжил арга зүйн ба санхүүгийн дэмжлэг үзүүлж, мэдээлэл харилцааны аргуудыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх
- ҮҮН-д орчин үеийн ЖСАХ-ийн нэр төрлийг олшруулж, үйлчүүлэгчдэд сонголт хийх боломж олгоход анхаарч ажиллах
- Гэр бүл төлөвлөлтийн талаар үйлчлүүлэгчдэд үнэн зөв мэдээлэл өгөх, гаж нөлөөг зөв тайлбарлах, үйлчлүүлэгчидтэй харьцах, харилцааны талаар анхаарч ажиллах

1.1 СУДАЛГААНЫ ҮНДЭСЛЭЛ, ЗОРИЛГО

Монгол улс нь дэлхийн хамгийн бага хүн амын нягтралтай улсуудын нэг юм. Сүүлийн жилүүдэд эх, нялхсын эндэгдэл үндэсний хэмжээнд буурч байгаа хэдий ч зарим бүс нутгийн ялгавартай байдал тохиолдсоор байна. Түүнчлэн улсын хэмжээнд нярайн эндэгдэл, амьгүй төрөлт, жирэмсний ба төрөлтийн хүндрэлийн тоо мэдэгдэхүйц буурахгүй байсаар байна. Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны дараах гүнзгийрүүлсэн судалгаагаар хүн амын гэр бүл төлөвлөлт, жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгслийн хэрэгцээ болон хангагдаагүй хэрэгцээ ихэсч байгааг тогтоосон. Манай орны хүн амын дотор эзлэх залуучуудын хувь өндөр байгаа нь цаашид жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгслийн хэрэгцээ өсөх, гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээний хэрэгцээ тасралтгүй нэмэгдэх магадлалтайг харуулж байна. Хэдийгээр жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгслийн талаарх олон нийтийн мэдлэг дээшилж байгаа ч улсын хэмжээнд үр хөндөлтийн тохиолдол өндөр байгаа нь анхаарал татаж байна.

Монгол улсын хэмжээнд нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээг хөдөө орон, нутагт 233 сум, сум дундын эрүүл мэндийн төв, хот суурин газарт 299 ӨЭМТ, аймаг дүүргийн нэгдсэн эмнэлэг ба бүсийн оношлогоо эмчилгээний төвүүд, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв үзүүлдэг. Эдгээр үйлчилгээ үзүүлэх нэгж дэх орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгсэл, нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмж нь хэрэгцээт тусламж үйлчилгээг чанартай, тасралтгүй хүргэх гол үндэс юм. Түүнчлэн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг нэгжид орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх арга, хэрэгсэл, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй

шаардлагатай эмийг хүртээмжтэй байлгах нь бүх шатлалын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг хангах нэн чухал үзүүлэлт төдийгүй эхийн эндэгдлийг бууруулахад чиглэсэн зохистой стратегийн арга хэмжээг төлөвлөх, боловсруулахад зайлшгүй харгалзан үзвэл зохих асуудлын нэг юм.

“Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тасалдалгүй хангамж”-ийн төсөл нь НҮБ-ын Хүн амын сангийн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тасралтгүй хангалтыг өргөжүүлэх дэлхий дахины хөтөлбөр”-ийн хүрээнд 2008 оноос Монгол улсад хэрэгжиж эхэлсэн. Тухайн улс, бүс ба дэлхий нийтийн түвшинд уг хөтөлбөрийн хэрэгжилтийг стандарт, загварчлагдсан “хяналт-үнэлгээ”-ний үзүүлэлтээр үнэлдэг. Энэхүү судалгааны гол зорилго нь эрүүл мэндийн ҮҮН дэх орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх арга, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг олон улсын стандарт “хяналт-үнэлгээ”-ний дагуу үнэлэхэд оршиж байлаа. Судалгааны зорилгыг биелүүлэхэд доорх зорилтуудыг дэвшүүлэн ажилласан. Үүнд:

- а) Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурваас доошгүй төрлийн аргаар үйлчилгээ үзүүлж буй ҮҮН-ийн хувь;
- б) Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таваас доошгүй төрлийн аргаар үйлчилгээ үзүүлж буй анхан шатны ҮҮН-ийн хувь;
- в) Сүүлийн 6 сарын хугацаанд орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх эм, хэрэгсэл тасарсан ҮҮН-ийн хувь;
- г) НҮБ-ын Хүн амын сангийн “Хяналт-үнэлгээ”-ний үзүүлэлтэд заасан зайлшгүй шаардлагатай эмийн жагсаалтад багтсан эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон

төрлийн эмээр тусламж үзүүлж буй ҮҮН-ийн хувь;

Манай оронд НҮБ-ын Хүн амын сангийн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тасалдалгүй хангамж”-ийн үнэлгээг олон улсын стандарт аргачлалаар 2011, 2012, 2013 онуудад гүйцэтгэсэн. Дээрх үнэлгээний дүнгээс харахад орчин үеийн гурван төрлийн жирэмслэхээс сэргийлэх аргаар үйлчилдэг ҮҮН-ийн хувь 2012 онд 97.6%, 2013 онд 97.7% байжээ. Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмээр тусламж үзүүлж буй ҮҮН-ийн хувь 2012 онд 82.3% байсан бол 2013 онд 89.3% болон нэмэгджээ.

2014 оноос НҮБ-ын Хүн амын сангийн ЖСАХ-д зориулсан санхүүжилт зогссон ба Монгол улсын Засгийн газраас хангаж, улсын эмнэлгээр үнэ төлбөргүй олгогдож эхэлсэн. Иймд 2015 онд орчин үеийн ЖСАХ, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийг ҮҮН-д үнэлэх, өмнөх онуудтай харьцуулан дүгнэлт өгөх шаардлага тулгарч байна.

ҮНЭЛГЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ БА МЕНЕЖМЕНТ

Энэхүү судалгааг НҮБ-ын Хүн амын сангийн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тасалдалгүй хангамж”-ийн үнэлгээг олон улсын стандарт аргачлалаар 2012, 2013 онуудад гүйцэтгэсэн туршлагатай баг гүйцэтгэсэн ба судалгааны багт анагаах ухаан, эх барих, эмэгтэйчүүд судлал, тархвар судлал, нөхөн үржихүйн эрүүл мэндийн, статистикийн судалгааны арга зүйг эзэмшсэн туршлагатай эмч, судлаачид ажилласан болно. ҮҮН дэх жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгсэл, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай амин чухал эмийн хүртээмжийн судалгааг гүйцэтгэхэд дэмжлэг үзүүлэхийг холбогдох бүх эрүүл мэндийн газраас хүссэн, албан бичиг илгээсэн.

Мэдээлэл цуглуулах багт хуваарьт, сонгогдсон ҮҮН-ийн нэрс бүхий жагсаалт, Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төвийн Ерөнхий захирлын дэмжлэг үзүүлэхийг хүссэн албан тоот, албан томилолт, ҮҮН-ийн жагсаалт, ҮҮН-ийг

болон үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үнэлэх асуумж, жолоочтой хийх гэрээ гэх мэт шаардлагатай бичиг баримтийг хүлээлгэн өгсөн. Судалгаанд хамрагдах ҮҮН болон аймаг, хотын эрүүл мэндийн газруудтай харилцаа холбоо тогтоох, сонгогдсон ҮҮН-д очиж ажиллах чиглэлийг тодорхойлох, төлөвлөх зэрэг ажлыг Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв зохион байгуулсан. НҮБ-ын Хүн амын сангийн суурин төлөөлөгчийн газар мэдээлэл цуглуулах, дүн шинжилгээ хийж боловсруулах явцыг хянаж, зөвлөгөө өгч ажилласан.

СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ

НҮБ-ын Хүн амын сангийн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тасралтгүй хангалтыг өргөжүүлэх дэлхий дахины хөтөлбөр”-өөс гаргасан улс, бүс ба дэлхий нийтийн түвшинд уг хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэх стандарт аргачлалын дагуу 2015 оны эрүүл мэндийн ҮҮН дэх орчин үеийн жирэмслэхээс сэргийлэх арга, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хүртээмжийн үнэлгээг хийв.

СУДАЛГААНЫ ЗАГВАР, ТҮҮВЭРЛЭЛТ

Үнэлгээг нэг агшны дүрслэх загвараар гүйцэтгэсэн. Судалгаанд ЖСАХ, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмээр үйлчилгээ үзүүлэх чадвартай ҮҮН-ийг төлөөлөх чадвар бүхий ҮҮН-ийг системчилсэн түүвэрлэлтээр хамруулсан.

Түүвэрлэлтэнд гэр бүл төлөвлөлт, жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм хэрэгсэл, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн өргөн хүрээтэй үйлчилгээг үзүүлэх чадвартай доорх төрлийн ҮҮН-ийг шатлалд тулгуурлан хамруулсан. Үүнд:

а) Анхан шатны тусламж үзүүлэх ҮҮН-Хөдөө орон нутагт жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгсэл, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг сумын ба сум дундын, тосгоны эмнэлэг, Улаанбаатар хотод ӨЭМТ, тосгоны эмнэлэг;

б) Хоёр дах шатлалын тусламж үзүүлэх ҮҮН- ЖСАХ, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг аймгийн нэгдсэн эмнэлэг, хөдөөгийн нэгдсэн

эмнэлгийн төрөх, эмэгтэйчүүдийн тасаг, Улаанбаатар хотын амаржих газар, дүүргийн нэгдсэн эмнэлэг,

в) Гурав дах шатлалын тусламж үзүүлэх ҮҮН- ЖСАХ, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлдэг Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, бүсийн оношлогоо эмчилгээний төв

г) Төрийн бус байгууллагын харьяа ҮҮН нөхөн үржихүйн эрүүл мэндийн чиглэлийн үйл ажиллагаа явуулдаг ТББ-ын санхүүжилттэй эмнэлэг

Түүвэрлэлтийн хүрээ: Улаанбаатар хотын бүх дүүрэг, аймаг тус бүрт үйлчилгээ явуулж байгаа гэр бүл төлөвлөлт, эхийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлдэг бүх ҮҮН-ийн бүртгэлийг Эрүүл мэнд, спортын яам, Хотын эрүүл мэндийн газраас авч, жагсаалт гаргасан. Энэ жагсаалтыг нь судалгаанд хамруулах ҮҮН-ийг сонгох түүвэрлэлтийн хүрээг тогтооход ашигласан болно. (Хавсралт 1)

Түүврийн хэмжээ: ҮҮН-ийн төрөл (анхан шат ба хоёр, гурав дах шатлал) ба тоог харгалзан, шатлал тус бүрийн эмнэлгийн байгууллагыг бүрэн төлөөлж чадах ҮҮН-ийн хамгийн бага тоог нь тогтоосон. Түүвэрлэлтийн хэмжээг тооцоход дараах томъёог ашигласан.

$$n = Z^2 p(1-p) / d^2$$

Үүнд: n- Хамгийн бага түүврийн хэмжээ
Z-Санамсаргүй алдааны мужид тохирох оноо

p-Шатлал тус бүрийн ҮҮН-ийн харьцаа (аравтын бутархайгаар илэрхийлэгдсэн)

d-Итгэлцүүрийн түвшин (аравтын бутархайгаар илэрхийлэгдсэн)

95%-ийн үнэн магадлалтай, 5%-ийн алдааны түвшинтэй нөхцлөөр тооцоолоход нийт түүвэрлэлтийн хэмжээ нь 211 ҮҮН байна. Эрүүл мэндийн үйлчилгээний шатлал тус бүрийн түүвэрлэлтийн хэмжээг тухайн аймаг, дүүрэг тус бүр дэх тухайн шатлалын ҮҮН-ийн тоотой пропорционал магадлалтай байхаар тооцоолсон. (Хавсралт 1)

Судалгаанд хамруулсан ҮҮН-ийг түүвэрлэлтэнд хамрагдах ижил магадлалтай байх нөхцлийг хангаж, статистик боловсруулалтын "R 3.1.3" программ хангамж ашиглан санамсаргүй

түүвэрлэлтийн аргаар сонгосон. Үүний тулд аймаг, дүүрэг тус бүр дэх ҮҮН буюу эрүүл мэндийн байгууллагын тоо ба сонгох ёстой ҮҮН-ийн тоог оруулан программын санамсаргүй сонгосон тоонд тохирох ҮҮН-ийг сонгов.

1.2 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАГЧДЫН СУРГАЛТ

Мэдээлэл цуглуулагчдын багийг эх барих эмэгтэйчүүдийн эмч, судлаачдаар бүрдүүлж, судалгааны арга зүйн сургалт зохион байгуулсан бөгөөд судалгааны зорилго, зорилт, арга, аргачлал, мэдээлэл цуглуулах хэрэгслийг танилцуулж, асуумжийг хэрхэн бөглөх, ЖСАХ, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн талаар болон өнөөгийн байдлаар мөрдөгдөж буй үндэсний удирдамж, жирэмсний хяналт, хог хаягдлын талаарх ЭМС-ын сайдын холбогдох тушаалын талаар мэдээлэл өгсөн. Энэхүү сургалтанд нийт 18 мэдээлэл цуглуулагч буюу эмч, судлаачид хамрагдсан. Түүнчлэн сонгогдсон ҮҮН-д очиж ажиллах зам чиглэл, өмнөх жилүүдийн судалгааны мэдээлэл цуглуулах явцад гарсан хүндрэлтэй асуудлын талаар өөрсдийн туршлагаа харилцан солилцсон.

1.3 МЭДЭЭЛЭЛ ЦУГЛУУЛАЛТ

2015 оны 10-11 сард Улаанбаатар хот болон хөдөө орон нутгаас сонгогдсон ҮҮН-ээс судалгааны мэдээллийг цуглуулав. Судалгааны 5 баг бүс нутгаар (Баруун, Төвийн, Хангайн, Зүүн ба Улаанбаатар) ажилласан. Анхан шатны үйлчилгээ үзүүлж буй ҮҮН-ийн онцлогоос хамаарч ӨЭМТд зөвхөн ЖСАХ-ийн хангамжийг үнэлсэн бол сум, сум дундын эмнэлэгт ЖСАХ, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндэд зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийг тус тус үнэлсэн.

1.4 МЭДЭЭЛЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ, ҮР ДҮНГИЙН ТАНИЛЦУУЛГА

Судалгааны мэдээлэл цуглуулсны дараа мэдээлэл боловсруулах асуумжийг шалгаж, нээлттэй асуултыг кодолж, Epidata 2.0 программ ашиглан, компьютерт 2 удаа шивж оруулан, мэдээллийг нэгтгэн, гарсан зөрүүг залруулсан. Мэдээллийг хянаж засах,

мэдээллийн үндсэн боловсруулалтыг “R 3.1.3” программаар хийж гүйцэтгэлээ. НҮБ-ын Хүн амын сангийн “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тасалдалгүй хангамжийн хөтөлбөр”-өөс боловсруулан гаргасан стандарт загвар, хүснэгтийг ашиглан мэдээллийг илэрхийлсэн. Түүнчлэн зарим үр дүнг дүрслэх аргаар зургаар үзүүлсэн. Үүнд ҮҮН-ийн газарзүйн бүсийн байршил, үйлчилгээ үзүүлэх гурван шатлалаас сонгогдсон ҮҮН-ийн хувь, ЖСАХ, эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмээр хангаж үйлчилж байгаа ҮҮН-ийн хувийг зургаар илэрхийлж тайланд тусгасан. Тодорхой хувьсагчуудын уялдааг статистик шалгуураар шалгав.

НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТАЛААР ҮНДЭСНИЙ ХЭМЖЭЭНД МӨРДӨГДӨЖ БҮЙ ХӨТӨЛБӨР, УДИРДАМЖ, ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БҮЙ БАЙГУУЛЛАГА

Сүүлийн арван жилдэх, хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулж, Мянганы хөгжлийн зорилтод хүрэх боломж бүрдүүлэхийн тулд Монгол улсын засгийн газраас нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөр боловсруулан, хэрэгжүүлж байна. Түүнчлэн “Эрүүл мэндийн салбарыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”, “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний дөрөвдүгээр хөтөлбөр” (2012-2016), “Эх, нярайн эрүүл мэнд стратеги (2011-2015)” зэрэг бодлогын баримт бичгүүдэд хүн амын нөхөн үржихүйн эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой асуудлууд тусгагдсан. 2005 онд батлагдсан “Эрүүл мэндийн салбарыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө”-нд 2015 он гэхэд хүн амын дундаж наслалтыг уртасгах, эх, хүүхэд, нялхсын эндэгдлийн түвшинг бууруулах, хоол хүнс түүний дотор эмэгтэйчүүд, хүүхдийн хүнсний бичил элементийн хангамжийг сайжруулах, ариун цэвэр эрүүл ахуйг сайжруулж, цэвэр усны хүртээмжийг нэмэгдүүлэх, ХДХВ/ДОХ-ын халдвараас сэргийлэх, хүн амын тогтвортой өсөлтийг хангах, өрхийн эрүүл мэндийн зардлыг бууруулж, ялангуяа эмзэг бүлгийн өрхөд илүү анхаарах, төвлөрлийг сааруулсан эрүүл мэндийн тогтолцооны хүрээнд орон нутагт үр нөлөөтэй байх, үйлчлүүлэгчдэд ээлтэй эмнэлгийн байгууллагын тоог нэмэгдүүлэх зэрэг хэтийн үр нөлөөнд хүрэхээр зорьж байна.

“Нөхөн үржихүйн эрүүл мэндийн үндэсний дөрөвдүгээр хөтөлбөр (2012-2016)”-т нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн тогтвортой хангамжийг сайжруулах стратегийг боловсруулж хэрэгжүүлэх ёстой гэж заасан билээ.

Эдгээр үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад хэрэгцээнд суурилсан нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангалт хийгдэж

байна. 2003 онд эх баригч нарт зориулсан “Жирэмслэлт, төрөлт, төрсний дараах үе ба нярайн тусламжийн удирдамж”-ийг боловсруулан нэвтрүүлж байна. ДЭМБ-ын гаргасан удирдамжийн дагуу 2007 онд Монгол хувилбарыг шинэчлэн хоёрдах хэвлэлээ гаргасан. Энэ удирдамжийн дагуу зарим сумдын эх баригчид сургалтанд хамрагдаж, цаашид эх баригч нарын сургалтын хөтөлбөрт уг удирдамжийг оруулж өгсөн болно. 2009 онд “Нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн үндэсний стратеги (2009-2013)” батлагдсан. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эм, хэрэгслээр тасралтгүй хангах гэдэг нь хэрэгцээт хүн амыг сонголттой, чанартай ЖСАХ ба бусад нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслээр найдвартай хангах явдал юм. ҮҮН нь нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эм, хэрэгслээр тасралтгүй хангах үүргийг төсвийн ба төсвийн бус хангамжаар хэрэгжүүлдэг. Харин жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгслийн хангамжийг төсвийн бус хангамжаар хэрэгжүүлдэг байснаа 2009 оноос эхлэн улсын төсвөөр тодорхой хэсгийг нь санхүүжүүлж эхлээд байна.

2.1 ЖСАХ-ИЙН УДИРДАМЖ

Үндэсний удирдамжийн дагуу ӨЭМТ нь анхан шатны эмнэлгийн хувьд ЖСАХ-ийн гурван төрөл буюу эр бэлгэвч, уух эм, тариагаар үйлчлэх ёстой. СЭМТ нь анхдагч шатлалын эмнэлгийн хувьд орчин үеийн ЖСАХ-ийн дөрвөн төрөл буюу эр бэлгэвч, уух эм, тариа ба ерөндгөөр үйлчлэх үүрэгтэй.

Суулгацын хувьд үндэсний удирдамжид тусгагдаагүй хэдий ч хоёр ба гурав дах шатлалын эмнэлгийн мэргэжлийн эмч нарт сургалт хийгдэж тодорхой хэмжээний Импланон, Жадель зэрэг суулгацууд нь

Хүснэгт 1. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгслээр хангах үндэсний удирдамж

ЖСАХ	Анхан шатны ҮҮН		Хоёр дах шатлалын ҮҮН				Гурав дах шатлалын ҮҮН	
	ӨЭМТ	Сум, сум дундын эрүүл мэндийн төв	Аймгийн нэгдсэн эмнэлэг	Дүүргийн эрүүл мэндийн төв	Хөдөөгийн нэгдсэн эмнэлэг	Амаржих газар	Бүсийн оношлогоо эмчилгээний төв	ЭХЭМҮТ
Эр бэлгэвч	+	+	+	+	+	+	+	+
Хавсарсан дааврын уух эм	+	+	+	+	+	+	+	+
Яаралтай уух эм	-	-	+	+	+	+	+	+
Тариа	+	+	+	+	+	+	+	+
Ерөндөг	-	+	+	+	+	+	+	+
Умайн гуурсан хоолой боох мэс ажилбар	-	-	+	-	+	+	+	+
Суулгац	-	-	+	-	+	+	+	+

ҮҮН- Үйлчилгээ үзүүлэх нэгж,

(+) Тухайн эм, хэрэгслээр үйлчилгээ үзүүлнэ

(-) Тухайн эм, хэрэгслээр үйлчилгээ үзүүлдэггүй

2013 оноос эхлэн ЭМСЯ-ны хуваарилалтаар олгогдож ирсэн.

2.2 ЭХ БАРИХЫН БА НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН УДИРДАМЖ

Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн үндэсний удирдамжид Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зөвлөмж болгож буй эхийн эндэгдэлд нөлөөлж буй үндсэн гурван шалтгаанаас сэргийлэх, эмчлэх эмийн бэлдмэлийг хамруулж үзсэн. Нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон эмэнд Окситоцин, Магни сульфат тариагаар ба халдварын эсрэг, даралт бууруулах зэрэг өргөн хэрэглэгддэг бусад 5 эм багтдаг. Эдгээр эм бэлдмэл нь дараах эмгэг, хүндрэлээс урьдчилан сэргийлэх, эмчлэх зорилготой. Үүнд:

- Цус алдалт (Окситоцин, Мизопростол)
- Манас таталт, манас таталтын урьдал (Магни сульфат тариагаар)
- Эх ба нярайн үжил халдвар (Ампициллин, Бензатин пенициллин, Гентамицин, Цефиксим, Метронидазол)

2.3 МОНГОЛ УЛСАД ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БҮЙ БАЙГУУЛЛАГА


2015 оны байдлаар Монгол улсад нийт 600 орчим эмнэлгийн байгууллага үйл ажиллагаа явуулж, нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үзүүлж байна. Эдгээр байгууллага үзүүлж байгаа тусламж үйлчилгээний хувьд гурван үндсэн шатлалд хуваагдана:

- Анхан шатны эмнэлэг-ӨЭМТ, сум, сум дундын ба тосгоны эмнэлэг, төрийн бус байгууллагын эмнэлэг. СЭМТ нь улсын байгууллага бол ӨЭМТ-үүд нь нөхөрлөл хоршоо буюу улсын ажлыг гэрээгээр гүйцэтгэдэг хувийн хэвшлийн байгууллага юм.
- Хоёр дах шатлалын эмнэлэг-Дүүргийн эрүүл мэндийн төвийн Нөхөн үржихүйн эрүүл мэндийн кабинет, Аймгийн нэгдсэн эмнэлэг, Нийслэлийн амаржих газар, Аймгийн ба хөдөөгийн нэгдсэн эмнэлгийн төрөх тасаг.
- Гурав дах шатлал: ЭХЭМҮТ, Бүсийн оношлогоо, эмчилгээний төв (БОЭТ)
Гэр бүл төлөвлөлтийн тусламжийг дээрх бүх байгууллага үзүүлдэг бол, төрөх үеийн тусламжийг ӨЭМТ, дүүргийн эрүүл мэндийн төвүүд үзүүлдэггүй болно.

3.1 СУДАЛГААНД ХАМРАГДСАН ҮҮН-ИЙН ТАНИЛЦУУЛГА

3.1.1 ҮҮН-ийн газарзүйн байршил

Судалгааг бүх аймаг, нийслэл Улаанбаатар хотоос сонгогдсон ҮҮН-ийг хамруулан гүйцэтгэсэн.



Зураг 1. Үнэлгээнд хамрагдсан ҮҮН-ийн тоо, бүсчлэлээр

Судалгаанд Улаанбаатар хотоос хамгийн олон (70) ҮҮН хамрагдсан бол Хангайн (42), төвийн (40) бүс удаалж, хамгийн цөөн эмнэлэг баруун (33) болон зүүн (20) бүсээс сонгогдов. Судалгаанд хамрагдсан ҮҮН-ийн гуравны нэгээс илүү нь (34.1% буюу 70/205) хотоос сонгогдсон бол гуравны хоёр нь (65.9% буюу 135/205) хөдөө, орон нутгийг төлөөлөн оролцсон.

(Хүснэгт 2)

Судалгаанд хамрагдсан ҮҮН-ийг анхан шатны эмнэлэг болох ӨЭМТ ба СЭМТ нь (76.1%), хоёр дах шатлалын аймгийн болон хөдөөгийн нэгдсэн эмнэлэг (10.7%), дүүргийн нэгдсэн эмнэлэг 6.3%, амаржих газар (1.5%), гурав дах шатлалын эмнэлгийн хувьд бүсийн оношлогоо, эмчилгээний төв (2.4%), Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв (0.5%) хувийг тус тус бүрдүүлжээ.


Хүснэгт 2. Судалгаанд хамрагдсан ҮҮН, бүс нутаг, эмнэлгийн төрлөөр

Бүсчлэл	ҮҮН								
	Сум ба Өрхийн ЭМТ	ТББ-ын эмнэлэг	Тосгоны эмнэлэг	Аймгийн ба хөдөөгийн НЭ	Дүүргийн НЭ	Амаржих газар	ЭХМӨҮТ	БОЭТ	Дүн
Баруун	26	-	-	6	-	-	-	1	33
Хангай	34	1	-	5	-	-	-	2	42
Төв	30	-	1	8	-	-	-	1	40
Зүүн	16	-	-	3	-	-	-	1	20
Улаанбаатар	50	2	1	-	13	3	1	-	70
Дүн	76.1%	1.5%	1.0%	10.7%	6.3%	1.5%	0.5%	2.4%	205

3.1.2 ҮҮН-ийн төрөл, шатлал

Судалгаанд оролцсон ҮҮН-ийн өмчлөлийн хувьд төрийн ба төрийн бус байгууллагын эмнэлэг байснаас дийлэнх ҮҮН-ийн (98.5%) төрийн эмнэлэг байсан бол төрийн бус байгууллагын 3 эмнэлэг хамрагдсан.

ҮҮН-ийн эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх шатлалын хувьд анхан шатны эмнэлэг 78.0%, хоёр дах шатлалын эмнэлэг 19.0%, гурав дах шатлалын эмнэлэг 3.0% тус тус оролцжээ. (Зураг 2).



Зураг 2. Судалгаанд хамрагдсан үйлчилгээ үзүүлэгч нэгжийн төрөл (хувиар)

3.1.3 ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧ НЭГЖ БА ЭМ, ХЭРЭГСЭЛ НИЙЛҮҮЛЭХ ХАНГАН НИЙЛҮҮЛЭХ БАЙГУУЛЛАГА ХООРОНДЫН ЗАЙ.

СЭМТ нь аймгийн эрүүл мэндийн газраас, Улаанбаатар хотын болон хөдөө орон нутгийн ӨЭМТ нь аймаг, дүүргийн эрүүл мэндийн нэгдлээс нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгслийн хангалтаа хийдэг бол Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, бүсийн оношлогоо, эмчилгээний төв, аймгийн нэгдсэн эмнэлэг, амаржих газар ба дүүргийн нэгдсэн эмнэлэг нь “Монгол Эм-импекс концерн”-оос шууд ЖСАХ-ийн хангамжаа авдгийг тооцон судалгааг хийсэн. Газарзүйн байршлаас хамаарч ҮҮН-ээс хангамжийн байгууллага хүртэлх зайг тооцоходоо 49 км хүртэл, 50-99 км, 100-аас дээш гэсэн байдлаар хувааж судалсан.

Судалгаанд хамрагдсан ҮҮН-ийн 57.6%

нь хамгийн ойрын ханган нийлүүлэх байгууллага хүртэлх зайны хувьд 50 км хүртэл байсан бол 31.2% нь 100-аас дээш км зайтай, үлдсэн (11.2%) нь 50-99 км зайд оршиж байв. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Үнэлгээнд хамрагдсан ҮҮН-ээс нөхөн үржихүйн эрүүл мэндийн эм, хэрэгсэл нийлүүлэх байгууллага хүртэлх зай (км-ээр)

Хамгийн ойрын ханган нийлүүлэх байгууллага хүртэлх зай (км)	Хувь	Тоо
0-49	57.6	118
50-99	11.2	23
100-аас дээш	31.2	64
Нийт	100	205

3.2. ҮҮН-ИЙН ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН АРГА, ХЭРЭГСЛИЙН ХАНГАМЖ

3.2.1 ГУРАВ БА ТҮҮНЭЭС ДЭЭШ ТӨРЛИЙН ОРЧИН ҮЕИЙН ЖСАХ-ЭЭР ҮЙЛЧИЛЖ БАЙГАА ҮҮН

Судалгаанд хамрагдсан нийт 205 эмнэлгийн 71.7% нь жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн (дор хаяж) аргаар үйлчилгээ үзүүлж байна. Гурав дах шатлалын эмнэлгийн 83.3%, хоёр дах шатлалын эмнэлгийн 71.1% нь гурван төрлийн ЖСАХ-ээр үйлчилж байсан бол анхан шатны эмнэлэг 71.4% байлаа. Гурав ба түүнээс дээш төрлийн орчин үеийн ЖСАХ-ээр үйлчилж байгаа байдал нь ҮҮН-ийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх шатлал хооронд статистик магадлалтай ялгаа гараагүй ($p > 0.183$). (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж байгаа хувь ҮҮН-ийн шатлалаар

ҮҮН-ийн шатлал	ҮҮН-ийн хувь		Дүн
	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж буй	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм хэрэгслээр үйлчлээгүй	
Анхан шат	71.4	28.6	161
Хоёр дах шатлал	71.1	28.9	38
Гурав дах шатлал	83.3	16.7	6
Дүн	71.7	28.3	205

Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр Улаанбаатар хотод хамгийн бага буюу (62.9%), төвийн бүсэд хамгийн олон ҮҮН (85.0%) үзүүлж

байлаа. Бүс хооронд гурван төрлийн орчин үеийн ЖСАХ-ийн хангамж ялгаатай боловч статистик ач холбогдолгүй ($p=0.077$) байна. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж байгаа хувь (бүсчлэлээр)

Бүсчлэлээр	ҮҮН-ийн хувь		Дүн
	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж буй	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчлээгүй	
Баруун	81.8	18.2	33
Хангай	66.7	33.3	42
Төв	85.0	15.0	40
Зүүн	70.0	30.0	20
Улаанбаатар	62.9	37.1	70
Дүн	71.7	28.3	205

Судалгаанд хамрагдсан хөдөө орон нутгийн эмнэлгүүдийн (76.3%), Улаанбаатар хотын (62.9%) нь жирэмслэхээс сэргийлэх гурван төрлийн эм, хэрэгслээр хангагдаж, үйлчилгээ үзүүлж байв. (Хүснэгт 6)

Хүснэгт 6. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж байгаа хувь (ҮҮН-ийн байршлаар)

Байршил	ҮҮН-ийн хувь		Дүн
	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж буй	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчлээгүй	
Хот	62.9	37.1	70
Хөдөө	76.3	23.7	135
Дүн	71.7	28.3	205

Судалгаанд хамрагдсан төрийн бус байгууллагын эмнэлгийн 33.3%, төрийн өмчит ҮҮН-ийн 73.5% нь орчин үеийн гурван төрлийн ЖСАХ-ээр үйлчилдэг байна.

Хангамжийн байгууллагаас 49 км хүртэлх зайд байрлалтай ҮҮН-д жирэмслэхээс сэргийлэх эм хэрэгслийн нийлүүлэлт 69.5%, 50-99 км-т 65.2% байсан бол 100

ба түүнээс дээш км зайд харьцангуй өндөр (78.1%) байгаа нь тогтоогдов. Хангамжийн байгууллагаас алслагдсан зай нь гурван төрлийн ЖСАХ-ийн нийлүүлэлтэнд статистик магадлалтай ялгаа ($p=0.35$) ажиглагдасангүй. (Хүснэгт 7)

Хүснэгт 7. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж байгаа хувь (ҮҮН-ээс хангамжийн газар хүртэлх зайгаар)

Хамгийн ойрын эм, хэрэгсэл нийлүүлэх газар хүртэлх зай (км)	ҮҮН-ийн хувь		Дүн
	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж буй	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчлээгүй	
0-49	69.5	30.5	118
50-99	65.2	34.8	23
100- аас дээш	78.1	21.9	64
Дүн	71.7	28.3	205

Судалгаанд хамрагдсан анхан шатны ҮҮН-ийн гурван төрлийн ЖСАХ-ээр үйлчилж байгаа нь хангамжийн байгууллага хүртэлх зайнаас харьцангуй бага хамааралтай буюу 49 км дотор 71.3%, 50-99 км хүртэл 68.2%, 100 км ба түүнээс дээш үед 73.7% байв. Хоёр дах шатлалын эмнэлгийн хувьд 49 км хүртэл зайтай үед 62.5%, 100 км-ээс дээш үед хангамж 81.0% болж нэмэгдсэн

байдал ажиглагдлаа. Гурав дах шатлалын ҮҮН-үүд зайнаас хамаарахгүй бүгд орчин үеийн гурван төрлийн ЖСАХ-ээр үйлчилжээ. (Хүснэгт 8)

Хүснэгт 8. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж байгаа хувь (Шатлал, хангамжийн газар хүртэлх зайгаар)

Хамгийн ойрын эм, хэрэгсэл нийлүүлэх газар хүртэлх зай (км)		ҮҮН-ийн хувь		Дүн
		Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж буй	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн гурван төрлийн эм, хэрэгслээр үйлчлээгүй	
0-49 км	Анхан шат	71.3	28.7	101
	Хоёр дах шатлал	62.5	37.5	16
	Гурав дах шатлал	100.0		1
				118
50-99 км	Анхан шат	68.2	31.8	22
	Хоёр дах шатлал		100.0	1
	Гурав дах шатлал	-	-	-
				23
100-аас дээш км	Анхан шат	73.7	26.3	38
	Хоёр дах шатлал	81.0	19.0	21
	Гурав дах шатлал	100.0	0.0	5
				64
Дүн		71.7	28.3	205

3.2.2 Таван төрлийн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгслээр үйлчилгээ үзүүлж буй анхан шатны ҮҮН

Судалгаанд хамрагдсан нийт 205 эмнэлгийн 161 нь анхан шатны эмнэлэг байсан батэдгээрийн 30.4% нь жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн аргаар үйлчилгээ үзүүлж байна.

Орчин үеийн таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилж байгаа ҮҮН-ийн хувь Улаанбаатар хотод хамгийн бага (5.7%), байсан бол бусад бүсийн хангамж ойролцоо буюу зүүн бүс (31.2%), төвийн бүс (38.7%), хангайн бүс (40.0%), баруун бүс (57.7%) байлаа. Таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилж байгаа ҮҮН-ийн байрлаж байгаа бүсүүдэд хангамжийн ялгаа байгаа эсэхийг хи квадратын аргаар шалгахад $p < 0.001$ -ээс бага буюу Улаанбаатар хотын ҮҮН-ийн хангамж бусад бүс, нутгаас эрс муу байдал ажиглагдлаа. (Хүснэгт 9)

Хүснэгт 9. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн **таван төрлийн** эм, хэрэгслээр үйлчилж байгаа анхан шатны ҮҮН-ийн хувь, газарзүйн бүсээр

Бүсчлэлээр	ҮҮН-ийн хувь		Дүн
	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж буй	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслээр үйлчлээгүй	
Баруун	57.7	42.3	26
Хангай	40.0	60.0	35
Төв	38.7	61.3	31
Зүүн	31.2	68.8	16
Улаанбаатар	5.7	94.3	53
Нийт	30.4	69.6	161

Судалгаанд хамрагдсан хөдөө орон нутгийн ҮҮН-ийн (42.6%), Улаанбаатар хотын (5.7%) нь жирэмслэхээс сэргийлэх таван төрлийн эм, хэрэгслээр үйлчилгээ үзүүлж байв. Орчин үеийн ЖСАХ-ийн

хангамж ба ҮҮН-ийн хот, хөдөөгийн ялгаа нь статистик ач холбогдол бүхий ($p < 0.001$) байлаа. (Хүснэгт 10)

Хүснэгт 10. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн **таван төрлийн** эм, хэрэгслээр үйлчилж байгаа анхан шатны ҮҮН-ийн хувь, ҮҮН-ийн байршлаар

Байршил	ҮҮН-ийн хувь		Дүн
	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж буй	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслээр үйлчлээгүй	
Хот	5.7	94.3	53
Хөдөө	42.6	57.4	108
Дүн	30.4	69.6	161

Эм ханган нийлүүлэх байгууллагаас 49 км хүртэлх зайд буюу харьцангуй ойр байрлалтай ҮҮН-үүд жирэмслэхээс сэргийлэх таван төрлийн эм хэрэгслийн нийлүүлэлт 16.8%, 50-99 км үед 59.1% бол харин 100 км ба түүнээс дээш, харьцангуй алслагдсан зайтай үед 50.0% хангамжтай гарсан нь Улаанбаатар хотын ӨЭМТ-ийн хангамж тааруу байгаатай холбоотой байж болох юм. Таван төрлийн ЖСАХ-ийн нийлүүлэлт ба хангамжийн байгууллагаас алслагдсан зайны хамаарлыг бодож үзэхэд ойр байгаа ҮҮН-ийн хангамж статистикийн

ач холбогдол бүхий бага гарсан. (Хүснэгт 11).

Хүснэгт 11. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн **таван төрлийн эм**, хэрэгслээр үйлчилж байгаа анхан шатны ҮҮН-ийн хувь, ҮҮН-ээс эм ханган нийлүүлэх хангамжийн газар хүртэлх зайгаар

Хамгийн ойрын эм, хэрэгсэл нийлүүлэх газар хүртэлх зай (км)	ҮҮН-ийн хувь		Дүн
	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж буй	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслээр үйлчлээгүй	
0-49	16.8	83.2	101
50-99	59.1	40.9	22
100-аас дээш	50.0	50.0	38
Дүн	30.4	69.6	161

3.2.3 ҮНДЭСНИЙ УДИРДАМЖИЙН ДАГУУ ЭР БЭЛГЭВЧ, УУХ ЭМ, ТАРИАГААР ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЖ БҮЙ ӨЭМТ

Үндэсний удирдамжийн дагуу ӨЭМТ нь эр бэлгэвч, уух эм ба тариагаар үйлчлэх үүрэгтэй ба үнэлгээнд хамрагдсан нийт 85 ӨЭМТ-ийн 70.6% нь удирдамжийн дагуу үйлчилдэг байна. Бүсийн байдлаар судалж үзэхэд төвийн бүс (88.9%) хамгийн өндөр хангамжтай бол, Улаанбаатар хотын ҮҮН (66.0%), зүүн бүсэд 50.0% байв. Үндэсний удирдамжийн дагуу ЖСАХ-ийн нийлүүлэлтэнд бүсийн ялгаанд статистик ач

ходбогдол бүхий ялгаа ($p > 0.51$) илрээгүй. Эм, хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага хүртэл 5 км-ээс дотогш зайтай байрлах ҮҮН-ийн (71.2%), 6 км ба түүнээс дээш бол (68.4%) удирдамжид нийцүүлэн ажиллажээ. Төрийн бус байгууллагын хувьд зөвхөн 1/3 буюу 33.3% нь эр бэлгэвч, уух эм ба тариагаар үйлчилдэг дүнтэй байна. (Хүснэгт 12)

Хүснэгт 12. Эр бэлгэвч, уух эм ба тариагаар үйлчилдэг ӨЭМТ-ийн хувь

Үзүүлэлт	ӨЭМТ-ийн хувь		Дүн
	Эр бэлгэвч, уух эм, тариагаар үйлчилдэг	Эр бэлгэвч, уух эм, тариагаар үйлчилдэггүй	
ӨЭМТ	70.6	29.4	85
Бүсчлэлээр			
Баруун бүс	77.8	22.2	9
Хангайн бүс	76.9	23.1	13
Төвийн бүс	88.9	11.1	9
Зүүн бүс	50.0	50.0	4
Улаанбаатар	66.0	34.0	50
Хангамжийн газраас алслагдсан зай (км-ээр)			
0-5	71.2	28.8	66
6-аас дээш	68.4	31.6	19

Үнэлгээнд хамрагдсан нийт ӨЭМТ-ийн 14.1% нь таван төрлийн орчин үеийн ЖСАХ-ээр үйлчилдэг байна. Бүсийн хангамжийн хувьд баруун бүсийн ӨЭМТ-үүд (44.4%), Улаанбаатар хотын ҮҮН (4.0%), зүүн бүсэд огт хангамжгүй байв. Бүсийн ялгаа хангамжинд статистикийн хувьд үнэн магадлалтай ялгаатай ($p=0.004$)

байв. Орчин үеийн таван төрлийн ЖСАХ-ийн нийлүүлэлтэнд ӨЭМТ-өөс эм ханган нийлүүлэх байгууллага хүртэлх зай 5 км дотор үед 15.2%, 6 км түүнээс дээш үед 10.5 % буюу төдийлөн нөлөөгүй ажээ. (Хүснэгт 13)

Хүснэгт 13. Орчин үеийн **таван төрлийн** ЖСАХ-ээр үйлчилдэг ӨЭМТ-ийн хувь.

ӨЭМТ	ӨЭМТ-ийн хувь		Дүн
	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслээр үйлчилж буй	Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн таван төрлийн эм, хэрэгслээр үйлчлээгүй	
Бүсчлэлээр			
Баруун бүс	44.4	55.6	9
Хангайн бүс	23.1	76.9	13
Төвийн бүс	33.3	66.7	9
Зүүн бүс	00.	100.0	4
Улаанбаатар	4.0	96.0	50
Хангамжийн газраас алслагдсан зай (км-ээр)			
0-5	15.2	84.7	66
6-аас дээш	10.5	89.5	19
Дүн	14.1	85.9	85

3.2.4 ҮНДЭСНИЙ УДИРДАМЖИЙН ДАГУУ ЭР БЭЛГЭВЧ, УУХ ЭМ, ТАРИА, ЕРӨНДГӨӨР ҮЙЛЧИЛЖ БҮЙ СЭМТ

Үндэсний удирдамжийн дагуу СЭМТ нь эр бэлгэвч, уух эм, тариа ба ерөндгөөр үйлчлэх үүрэгтэй. Удирдамжид заасны дагуу үнэлж үзэхэд 73.2% нь шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг дүн гарчээ.

Эр бэлгэвч, уух эм, тариа, ерөндгийн нийлүүлэлт зөвхөн хангайн бүсэд хангалтгүй (57.1%) гарсан боловч бусад бүстэй харьцуулахад (75.0-82.4%) ялгаа бага ажиглагдлаа. СЭМТ-өөс эм, хэрэгсэл нийлүүлэх байгууллага хүртэлх зайнаас ЖСАХ-ийн хангамж хамаарч 49 км хүртэл зайтай үед харьцангуй илүү 81.2% байсан бол 100 км ба түүнээс дээш үед 70.6% хүрч буурчээ. (Хүснэгт 14)

Хүснэгт 14. Эр бэлгэвч, уух эм, тариа, ерөндгөөр үйлчилдэг СЭМТ-ийн хувь

Үзүүлэлт	СЭМТ-ийн хувь		
	Эр бэлгэвч, уух эм, тариа, ерөндгөөр үйлчилдэг	Эр бэлгэвч, уух эм, тариа, ерөндгөөр үйлчилдэггүй	Дүн
СЭМТ	73.2	26.8	71
Бүсчлэлээр			
Баруун бүс	82.4	17.6	17
Хангайн бүс	57.1	42.9	21
Төвийн бүс	81.0	19.0	21
Зүүн бүс	75.0	25.0	12
Улаанбаатар	-	-	-
Хангамжийн газраас алслагдсан зай (км-ээр)			
0-49 км	81.2	18.8	16
50-99 км	71.4	28.6	21
100-аас дээш	70.6	29.4	34
Дүн	73.2	26.8	71

Орчин үеийн таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилдэг СЭМТ-ийн эзлэх хувь 49.3% байсан ба хамгийн сайн хангамжтай нь баруун бүс (64.7%), хангамж тааруу нь төвийн бүс (38.1%) байв. Хангамжийн байгууллага хүртэлх зай 50-99 км хол байрласан үед 61.9%, харин 49 км дотор байрлаж байгаа СЭМТ-ийн 25.0% нь үйлчилжээ. Орчин үеийн таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилж байгаа

үед ханган нийлүүлэлтийн байгууллагын зайнаас хамаарч байгаа боловч статистик ач холбогдолгүй ($p=0.07$) байв. (Хүснэгт 15)

Хүснэгт 15. Орчин үеийн таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилдэг СЭМТ-ийн хувь

Үзүүлэлт	СЭМТ-ийн хувь		
	Таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилдэг	Таван төрлийн ЖСАХ-ээр үйлчилдэггүй	Дүн
СЭМТ	49.3	50.7	71
Бүсчлэлээр			
Баруун бүс	64.7	35.3	17
Хангайн бүс	52.4	47.6	21
Төвийн бүс	38.1	61.9	21
Зүүн бүс	41.7	58.3	12
Улаанбаатар	-	-	-
Хангамжийн газраас алслагдсан зай (км-ээр)			
0-49 км	25.0	75.0	16
50-99 км	61.9	38.1	21
100-аас дээш	52.9	47.1	34
Дүн	49.3	50.7	71

3.2.5 Судалгаа хийх үед жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн аргаар үйлчлэхгүй байсан шалтгаан

Тухайн ҮҮН ЖСАХ-ээр үйлчлэхгүй байгаа шалтгааныг хүснэгт 16-д харуулав. Орчин үеийн ЖСАХ тасарсан гол шалтгаан хангамжаас болсон байдал ажиглагдлаа. ҮҮН-ийн 95.2% нь хангамжийн байгууллагаас шалтгаалж эр бэлгэвчээр үйлчлээгүй байсан бол, эм бэлгэвч (62.1%), уух эм (93.3%), тариа (91.3%), ерөндөг (66.7%), яаралтай уух эм (87.1%) тус тус адил шалтгаанаар тасарчээ. Дараагийн түгээмэл шалтгаан нь ҮҮН-ээс хамаарч тасарсан байдал эм бэлгэвч (7.4%), уух эм (6.7%), яаралтай уух эм (4.8%), суулгац (5.0%) дээр илэрсэн.

Ерөндөг болон суулгацын хувьд сургагдсан ажилтан байхгүй, хэрэглэх нөхцөл бүрдээгүй зэрэг нь үйлчлэхгүй байх дийлэнх шалтгаан болжээ. (Хүснэгт 16)


Хүснэгт 16. Жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн эм, хэрэгсэл тасарсан шалтгаан

Шалтгаан	Орчин үеийн ЖСАХ						
	Эр бэлгэвч (n=21)	Эм бэлгэвч (n=161)	Уух эм (n=15)	Тариа (n=23)	Ерөндөг (n=15)	Яаралтай уух эм (n=124)	Суулгац (n=40)
Хангамжаас шалтгаалсан	95.2	62.1	93.3	91.3	66.7	87.1	37.5
ҮҮН-ээс шалтгаалсан	-	7.4	6.7	-	-	4.8	5.0
Эмийн сангаар зарагддаг болсон	-	14.3	-	4.3	-	2.4	-
Сургагдсан ажилтан байхгүй	-	-	-	-	20.0	-	35.0
Хэрэглэх нөхцөл бүрдээгүй	-	-	-	-	6.7	-	20.0
Бусад	4.8	16.2	-	4.3	6.7	5.6	2.5

3.3 Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж

ҮҮН дэх эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийн талаар зураг 3-т үзүүлээ. Судалгаанд хамрагдсан ҮҮН-д эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндэд зайлшгүй шаардлагатай эмийн хангалт харилцан адилгүй байлаа. Зайлшгүй шаардлагатай Магни сульфат (100.0%) ба Окситоцин (100.0%) бүх ҮҮН-д байгаа дүн гарсан. Антибиотикийн хувьд дийлэнх эмнэлгүүд

Ампициллин (90.6%), Гентамицин (92.2%), Метронидазол (84.3%) хангамжтай байсан ч Цефиксим (62.7%), Бензатин пенициллин (53.5%), Азитромицин (13.7%) зэрэг эмийн хангамж доогуур гарчээ. Даралт бууруулах эмийн хувьд Нифедипин (84.5%), Гидралазин (62.1%) ба Метилдопа (39.8%) зэрэг зарим эмийн хангамж хангалтгүй байна. (Зураг 3)



Зураг 3. ҮҮН дэх эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж

ҮҮН-ийн эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийг шатлалаар үзүүллээ. Халдварын эсрэг эмийн хангамж ҮҮН-ийн шатлалаас төдийлөн хамаарахгүй ойролцоо түвшинд байна. Харин төрөх үеийн тусламж үйлчилгээг илүү олон хүнд үзүүлдэг хоёр ба гурав дах шатлалын эмнэлгийн хувьд Гидралазин, Мизопростол ба Мифепристон зэрэг эмийн хангамж анхан шатны илүү байгаа нь ажиглагдлаа.

Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангалтанд бүсийн ялгаа өмнө оны судалгаанаас харьцангуй бага илэрсэн. Хот, хөдөөгийн байрлал эмийн хангамжид нөлөөтэй байгаа нь мөн тогтоогдлоо. Хотын ҮҮН-д эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай 11 эм нь хангалтын хувьд хөдөөний эмнэлгээс илүү хувьтай байгаа дүн ажиглагдлаа. Эмийн хангамжид, эмнэлгээс эм нийлүүлэх газар хүртэлх зай нөлөөлөх нь урьд хийгдсэн судалгаанаас багассан байлаа. (Хүснэгт 17)

Хүснэгт 17. Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж

Үзүүлэлт	Ампициллин	Азитромицин	Бензатин пенициллин	Дексаметазон	Кальци глюконат	Цефиксим	Гентамицин	Гидралазин	Магни сульфат	Метилдопа	Метронидазол	Мифепристон	Мизопростол	Нифедипин	Окситоцин	0.9% Натри хлорид
ҮҮН-ийн шатлал																
Анхан шат ҮҮН (n=71)	94.3	14.3	50.7	93.0	97.2	60.0	88.7	47.9	100	31.0	80.0	6.0	16.4	83.1	100	100
Хоёр дах шатлалын ҮҮН (n=26)	100	11.5	65.4	100	96.2	69.2	100	92.3	100	61.5	92.3	61.5	96.1	88.5	100	100
Гурав дах шатлалын ҮҮН (n=6)	83.3	16.7	33.3	100	100	66.7	100	100	100	50.0	100	33.3	83.3	83.3	100	100
Бүсчлэлээр																
Баруун (n=24)	95.6	20.8	39.1	95.8	100	26.1	87.5	70.8	100	45.8	79.2	27.3	27.3	75	100	100
Хангай (n=28)	96.4	10.7	50	89.3	100	85.7	96.4	75	100	32.1	89.3	18.5	51.9	89.3	100	100
Төв (n=30)	90.0	13.8	75.9	96.7	96.7	63.3	86.7	50.0	100	53.3	79.3	16.7	40.0	86.7	100	100
Зүүн (n=16)	100	12.5	31.2	100	93.8	62.5	100	37.5	100	18.8	87.5	13.3	26.7	81.2	100	100
Улаанбаатар (n=5)	100	0.0	80	80	80	100	100	100	100	40.0	100	80.0	100	100	100	100
Хот, хөдөө																
Хот (n=5)	100	0.0	80	100	80	100	100	100	100	40	100	80	100	100	100	100
Хөдөө (n=98)	94.8	14.4	52.1	94.9	97.9	60.8	91.8	60.2	100	39.8	83.5	19.1	38.3	83.7	100	100
Менежмент																
Төрийн (n=103)	95.1	13.7	53.5	95.1	97.1	62.7	92.2	62.1	100	39.8	84.3	22.2	41.4	84.5	100	100
ТББ (n=3)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хангамжийн байгууллага хүртэлх зай (км-ээр)																
0-49 (n=28)	96.4	10.7	57.1	92.9	96.4	64.3	92.9	67.9	100	42.8	82.1	29.6	48.1	82.1	100	100
50-99 (n=22)	95.2	14.3	50.0	90.9	95.4	66.7	90.9	45.4	100	36.4	71.4	5.0	25.0	90.9	100	100
100-аас дээш (n=53)	94.3	15.1	52.8	98.1	98.1	60.4	92.4	66.0	100	39.6	90.5	25.0	44.2	83.0	100	100
Дүн	95.1	13.7	53.5	95.1	97.1	62.7	92.2	62.1	100	39.8	84.3	22.2	41.4	84.5	100	100

3.3.1 Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамж

Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамж 2012 онд хийгдсэн судалгаагаар хоёр дах шатлалын эмнэлэгт 96.3%, 2013 онд 92.6% байсан бол 2015 онд хийсэн үнэлгээний үед нийлүүлэлт сайжирсан (100.0%) дүнтэй гарсан. Анхан шатны ҮҮН-ийн хувьд 2013 онд 86.3%

байснаа ялимгүй буурч 84.5% болсон. Гурав дах шатлалын хангамж 2013 онд 89.3% байсан нь 2015 онд 83.3% хүрч буурсан байна. (Хүснэгт 18)

Хүснэгт 18. Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн (хоёр чухал) эмийн хангамж, байгууллагын төрлөөр

ҮҮН-ийн шатлал	ҮҮН-ийн хувь		Дүн
	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамжтай	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамжгүй	
Анхан шатны ҮҮН	84.5	15.5	71
Хоёр дах шатлалын ҮҮН	100.0		26
Гурав дах шатлалын ҮҮН	83.3	16.7	6
Дүн	88.3	11.7	103

Зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамж бүсүүдэд харилцан адилгүй, зүүн бүс болон Улаанбаатар хотын ҮҮН дэх нийлүүлэлт (100.0%) байсан бол төвийн бүсэд (80.0%), баруун бүсэд (83.3%) ба хангайн бүсэд (92.9%) гарчээ. (Хүснэгт 19)

Хүснэгт 19. Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн (хоёр чухал) эмийн хангамж, бүсчлэлээр

Бүсчлэлээр	ҮҮН-ийн хувь		Дүн
	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамжтай	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамжгүй	
Баруун бүс	83.3	16.7	24
Хангайн бүс	92.9	7.1	28
Төвийн бүс	80.0	20.0	30
Зүүн бүс	100.0		16
Улаанбаатар	100.0		5
Дүн	88.3	11.7	103

Зайлшгүй шаардлагатай долоон эмийн хангамж нь төрөхийн тусламж үйлчилгээ үзүүлдэг Улаанбаатар хотын бүх (100.0%) эмнэлгүүдэд байсан бол хөдөө орон нутгийн ҮҮН-ийн 87.8% нь нөөцөлж, үйлчилгээ үзүүлжээ. (Хүснэгт 20)

Хүснэгт 20. Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн (хоёр чухал) эмийн хангамж (хот, хөдөөгөөр)

Байрлал	ҮҮН-ийн хувь		Дүн
	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамжтай	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамжгүй	
Хот	100	0.0	5
Хөдөө	87.8	12.2	98
Дүн	88.3	11.7	103

2015 оны судалгаагаар тухайн ҮҮН-ийн эм, хэрэгслийн ханган нийлүүлэх байгууллагаас хир зайтай байхаас эмийн хангамж төдийлөн хамаарахгүй байгаа нь сайн үзүүлэлт бөгөөд энэ нь сүүлийн жилүүдэд хөдөө орон нутгийн зам харилцаа

сайжирсан, тээврийн хэрэгслийн тоо нэмэгдсэнтэй холбоотой байж болох юм. (Хүснэгт 21)

Хүснэгт 21. Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн (хоёр чухал) эмийн хангамж (алслагдсан зайгаар)

Хангамжийн газраас алслагдсан зай (км)	ҮҮН-ийн хувь		Дүн
	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамжтай	Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамжгүй	
0-49	85.7	14.3	21
50-99	81.8	18.2	22
100-аас дээш	91.7	8.3	60
Дүн	88.3	11.7	103

3.3.2 Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн тасарсан шалтгаан

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн тасарсан гол шалтгаан нь хангамжийн байгууллага болон ҮҮН-ээс болжээ. Хангамжийн байгууллагаас шалтгаалж хамгийн их тасарсан эм нь Азитромицин (41.5%), Метилдопа (54.4%) мөн Бензатин пенициллин (53.5%) байв. ҮҮН-ээс шалтгаалж мөн Азитромицин (41.5%),

Цефиксим (42.9%), Мифепристон (22.4%) мөн Мизопростол (19.0%) тасарчээ. Зарим эмийн хувьд зах зээлд тасарсан байдал уг эмээр үйлчлэхгүй шалтгаан болжээ. Тухайлбал: Бензатин пенициллин (16.3%), Гидралазин (2.8%), Метилдопа (7.0%), Мифепристон (3.4%) ба Мизопростол (4.8%) нь зах зээлд тасарсаны улмаас үйлчлэхгүй байлаа. Сургагдсан ажилтан байхгүй гэсэн шалтгаанаар Мифепристон (32.8%) ба Мизопростол (42.9%) оор үйлчлээгүй тохиолдол гарсан. (Хүснэгт 22)


Хүснэгт 22. Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай долоон төрлийн эмийн хангамж тасарсан шалтгаан, хувиар

Шалтгаан	Ампициллин (n=7)	Азитромицин (n=84)	Бензатин пенициллин (n=44)	Дексаметазон (n=5)	Кальци глюконат (n=4)	Цефиксим (n=36)	Гентамицин (n=9)	Гидралазин (n=37)	Магни сульфат (n=0)	Метилдопа (n=57)	Метронидазол (n=12)	Мифепристон (n=58)	Мизопростол (n=42)	Нифедипин (n=15)
Хангамжаас шалтгаалсан	42.9	41.5	53.5	40.0	50.0	51.4	42.9	75.0	-	54.4	45.4	27.6	26.2	80.0
ҮҮН-ээс шалтгаалсан	57.1	34.1	14.0	60.0	25.0	42.9	57.1	19.4	-	29.8	45.4	22.4	19.0	20.0
Зах зээлд байхгүй	-	-	16.3	-	-	-	-	2.8	-	7.0	-	3.4	4.8	-
Сургагдсан ажилтан байхгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	32.8	42.9	-
Бусад	-	24.4	16.2	-	25.0	5.7	-	2.8	-	8.8	9.2	13.8	7.1	-

3.4 ЭХ БАРИХЫН БА НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЭМИЙН ХАНГАМЖ

Өмнөх үнэлгээнд зөвхөн НҮБ-ын Хүн амын сангийн стандарт асуумжийн дагуу, жагсаалтад орсон эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийг үнэлдэг байсан. 2015 онд НҮБ-ын Хүн амын сан ба судлаачид харилцан ярилцаж, стандарт эмийн жагсаалтыг өөрийн орны онцлогт тохируулан зарим төрлийн эмийг нэмэн өөрчилж, судалгааны мэдээлэл цуглуулсан. Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийн хувьд Магни сульфат, Окситоцин болон 0.9% Натри хлорид тус бүр бүх ҮҮН-д (100.0%) нөөцөнд байлаа. Антибиотикийн ханган нийлүүлэлт ҮҮН-үүдийн хувьд харилцан адилгүй байсан ба Цефазолины бүлгийн эмийн хувьд (86.4%), Метрогил (74.7%) ба Бензатин пенициллин (48.0%) тус бүр үйлчилжээ. ҮҮН-д зарим нэр төрлийн эмийн бэлдмэл Дексаметазон

(96.1%), Диазепам (92.2%), Адреналин (88.3%), Атропин (83.4%), Нифедипин (81.6%), Преднизалон (66.9%), Гидралазин (62.1%) мөн түүчлэн Метилдопаг (38.8%) нөөцөндөө байлгаж үйл ажиллагаандаа хэрэглэжээ.



Зураг 4. Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж

Уг судалгааг гүйцэтгэх үед эх барихын зайлшгүй шаардлагатай чухал 2 эм болох Окситоцин, Магни сульфат, түүнчлэн 0.9%-ийн Натри хлорид (100.0%) бүх шатлалын нөхөн үржихүйн эрүүл мэндийн ҮҮН-ийн нөөцөнд байжээ.

Антибиотик эмийн хангамж баруун бүсэд Цефазолин 75.0%, Метрогил 62.5%, Бензатин пенициллин 37.5% буюу хамгийн бага үзүүлэлттэй байсан бол төвийн бүсэд Цефазолин (90.0%), Метрогил 76.7%, Бензатин пенициллин 75.9% буюу антибиотикийн хангамжийн үзүүлэлт бусад бүсээс илүү сайн байлаа. Даралт бууруулах эмийн нийлүүлэлт бүс бүрээр ялгаатай байлаа. Баруун бүсэд Нифедипинийн хангамж 70.8%, зүүн бүсэд 75.0% Улаанбаатар хотод 100.0% байсан бол Метилдопагийн хангамж зүүн бүсэд 12.5%, хангайн бүсэд 32.1%, Улаанбаатар хотод 40.0% үлдсэн бүсүүдэд 50.0% тус тус үйлчилсэн үзүүлэлт илрэв.

Адреналины нийлүүлэлт бүсүүдэд харьцангуй тогтвортой зүүн бүсэд 81.2%, бусад бүсэд түүнээс дээш байсан бол, Атропин хангайн бүсэд хамгийн сул 71.4%, баруун бүсэд 79.1%, төвийн бүс 90.0%, зүүн бүс 93.7% ба Улаанбаатарт 100.0% нөөцөнд байв.

Шинээр гаргасан эмийн жагсаалт дах эмийн хамгийн муу хангамжтай нь Амидрон (14.5%), Метилдопа 38.8% болон Бензатин пенициллин 48.8% тус тус байв.

Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийг ҮҮН-ийн байрлал хамгийн ойр байрлах агуулахаас 49 км дотор, 99 км хүртэл болон 100 км-ээс дээш алслагдсан гэсэн байдлаар ангилж судалсан. Дийлэнх эмүүдийн хангамж алслагдсан байдлаас хамаарч өөрчлөгдөхгүй байсан боловч Атропин 50 км дотор байрлах ҮҮН-үүдэд 90.5%, 100 км-ээс дээш үед 83.3%, метрогил 85.7%, Диазепам 100.0%-иас 86.7% болж тус тус буурсан үзүүлэлт илэрсэн. (Хүснэгт 23)

Хүснэгт 23. Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж

Үзүүлэлт	Амидрон	Дексаметазон	Бензатин пенициллин	Преднизолон	Атропин	Цефазолин	Адреналин	Гидралазин	Магни сульфат	Метилдопа	Метрогил	Диазепам	Мизопростол	Нифедипин	Окситоцин	0.9% Натри хлорид
Байгууллагын төрөл																
Анхан шат (n=71)	11.3	94.4	50.0	56.3	77.5	83.1	84.5	47.9	100	29.6	69.0	91.5	16.9	78.9	100	100
Хоёр дах шатлал (n=26)	19.2	100	53.8	92.3	96.1	96.1	96.1	92.3	100	61.5	84.6	96.1	96.1	88.5	100	100
Гурав дах шатлал (n=6)	33.3	100	0.0	83.3	100	83.3	100	100	100	50.0	100	83.3	83.3	83.3	100	100
Бүсчлэлээр																
Баруун (n=24)	12.5	95.8	37.5	75.0	79.1	75.0	91.7	70.8	100	50.0	62.5	87.5	29.2	70.8	100	100
Хангай (n=28)	3.6	92.9	35.7	53.6	71.4	92.9	92.9	78.6	100	32.1	75.0	92.9	50.0	89.3	100	100
Төв (n=30)	23.3	100	75.9	63.3	90.0	90.0	83.3	46.7	100	50.0	76.7	93.3	40.0	83.3	100	100
Зүүн (n=16)	0.0	93.7	31.2	75.0	93.7	81.2	81.2	37.5	100	12.5	81.2	93.7	25.0	75.0	100	100
Улаанбаатар (n=5)	80.0	100	60.0	100	100	100	100	100	100	40.0	100	100	100	100	100	100
Байршил																
Хот (n=5)	80.0	100	60	100	100	100	100	100	100	40	100	100	100	100	100	100
Хөдөө(n=98)	11.2	95.9	47.4	65.3	82.6	85.7	87.7	60.2	100	38.8	73.4	91.8	37.8	80.6	100	100
Менежмент																
Төрийн (n=103)	14.5	96.1	48.0	67.0	83.5	86.4	88.3	62.1	100	38.8	74.8	92.2	40.8	81.6	100	100
ТББ (n=3)	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
Хамгийн ойр байрлах агуулахаас алслагдсан зай																
0-49 (n=21)	23.8	95.2	47.6	42.8	90.5	85.7	85.7	52.4	100	42.9	85.7	100	28.6	80.9	100	100
50-99 (n=22)	4.5	95.4	52.4	77.3	77.3	95.4	86.4	50.0	100	31.8	68.2	100	27.3	81.8	100	100
100-аас дээш (n=60)	15.0	96.7	46.7	71.7	83.3	83.3	90.0	70.0	100	40.0	73.3	86.7	50.0	81.7	100	100

3.4.1 Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж тасарсан шалтгаан

Эмийн хангамж зонхилон хоёр төрлийн шалтгаанаас болж тасарч байгааг хүснэгт 26-д илэрхийлэв. Судалгаанд хамрагдагсдын хариултаас, хамгийн олон давтамжтай тасарсан эмүүдийг сонгож үзэхэд Амидрон (33.7%), Метилдопа (55.5%), Мизопростол

(26.8%) ба Бензатин пенициллин (54.0%) нь хангамжаас шалтгаалж тасарчээ. Амидрон (43.0%), Бензатин пенициллин (18.0%), Преднизолон (48.5%), Метилдопа (31.7%) зэрэг эм нь ҮҮН-ээс хамаарч тасарчээ. Зах зээлд эм тасарсан учир тасарсан хэмээн Бензатин пенициллин (12.0%), Атропин (7.1%), Метилдопа (6.3%)-гийн нөөц ҮҮН-д байхгүй байгааг тайлбарласан байна. (Хүснэгт 24)

Хүснэгт 24. Эх барихын ба НҮЭМ-ийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамж тасарсан шалтгаан

Шалтгаан	Амидрон (n=86)	Дексаметазон (n=6)	Бензатин пенициллин (n=50)	Преднизолон (n=33)	Атропин (n=14)	Цефазолин (n=15)	Адреналин (n=8)	Гидралазин (n=37)	Метилдопа (n=63)	Метрогил (n=22)	Диазепам (n=6)	Мизопростол (n=56)	Нифедипин (n=15)
Хангамжаас шалтгаалсан	33.7	50.0	54.0	30.3	28.6	53.3	62.5	62.2	55.5	18.2	50.0	26.	73.3
ҮҮН-ээс шалтгаалсан	43.0	16.7	18.0	48.5	57.1	20.0	25.0	27.0	31.7	68.2	50.0	25.0	13.3
Зах зээлд байхгүй	-	-	12.0	-	7.1	-	-	-	6.3	-	-	-	-
Сургагдсан ажилтан байхгүй	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	42.9	-
Бусад	23.3	33.3	16.0	21.2	7.1	26.7	12.5	10.8	6.3	13.6	-	5.3	13.4

3.5 ЭХ БАРИХЫН БА НӨХӨН ҮРЖИХҮЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЗАРИМ ХЭРЭГСЛИЙН ХАНГАМЖ

Өмнөх үнэлгээний дүгнэлтэнд үндэслэн судалгаанд зөвхөн эм төдийгүй нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай зарим нэр төрлийн хэрэгслийн хангамжийг үнэлэх талаар тусгагдсан. Иймээс 2015 оны судалгааны бэлтгэлийн явцад НҮБ-ын Хүн амын сан ба судлаачдын баг харилцан зөвшилцөж, эмийн стандарт жагсаалтанд нэмэлтээр уян зүү, дуслын систем, нярайн амьсгалын маск зэрэг зарим төрлийн зайлшгүй шаардлагатай эмнэлгийн хэрэгслийг жагсааж, мэдээлэл цуглуулсан.

Хүснэгтээс үзэхэд 24 хэмжээтэй уян зүүний хангамж анхан шатанд 71.8%, хоёр дах шатлалд 84.6%, гурав дах шатлалд 83.3% байв. 18 хэмжээтэй уян зүүний хувьд анхан шатанд 74.6%, хоёр дах шатлалд 96.1%, гурав дах шатлалд 83.3% тус тус нөөцөлжээ.

Дуслын системийн нийлүүлэлт анхан шатанд 98.6% бусад шатлалын ҮҮН-үүдэд 100.0% байгаа нь ажиглагдлаа. Нярайн амьсгалын маск хоёр, гурав дах шатлалын эмнэлгүүдэд тус бүр 100.0% , анхан шатанд дутуу нярайн маск 80.0%, гүйцэд нярайн маск 97.2% байжээ. Бүсчлэлийн хувьд харилцан адилгүй байсан ба Улаанбаатар хотын хэрэгслийн нийлүүлэлт харьцангуй илүү байдалтай гарсан. ҮҮН-ийн ханган нийлүүлэх байгууллагаас алслагдсан байдал хэрэгслийн хангамжид статистик ач холбогдол бүхий нөлөө үзүүлээгүй. (Хүснэгт 25)

Хүснэгт 25. Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай зарим хэрэгслийн хангамж

Үзүүлэлт	Уян зүү 24 G	Уян зүү 18 G	Дуслын систем	Амбу	Дутуу нярайн амьсгалын маск	Гүйцэд нярайн амьсгалын маск	Хүчилтөрөгчийн баллон/өтгөрүүлэгч	Насанд хүрсэн хүний амьсгалын маск	Салиа соруулах гуурс
Тусламжийн шатлал									
Анхан шат (n=71)	71.8	74.6	98.6	95.8	80.0	97.2	91.4	97.2	88.7
Хоёр дах шатлал (n=26)	84.6	96.1	100.0	96.1	100.0	100.0	100.0	92.3	100.0
Гурав дах шатлал (n=6)	83.3	83.3	100.0	100	100.0	100.0	100.0	100.0	100.0
Бүсчлэлээр									
Баруун (n=24)	75.0	87.5	100.0	95.8	91.7	100.0	87.5	95.8	83.3
Хангайн (n=28)	78.6	75.0	96.4	92.8	82.1	96.4	92.8	96.4	89.3
Төвийн (n=30)	63.3	80.0	100.0	100	80.0	96.7	100.0	96.7	96.7
Зүүн (n=16)	87.5	81.2	100.0	100	93.3	100.0	93.7	100.0	100.0
Улаанбаатар (n=5)	100	80.0	100.0	80.0	100.0	100.0	100.0	80.0	100
Байршил									
Хот (n=5)	100	80.0	100.0	80.0	100.0	100.0	100.0	80.0	100
Хөдөө (n=98)	74.4	80.6	98.9	96.9	85.6	97.9	93.8	96.9	91.8
Менежмент									
Төрийн (n=103)	75.7	80.6	99.0	96.1	86.3	98.0	94.1	96.1	92.2
ТББ (n=3)	-	-	-	-	-	-	-	-	-
Хангамжийн газраас алслагдсан зай (км)									
0-10 (n=21)	61.9	95.2	100.0	90.5	75.0	95.2	85.7	90.5	95.2
10-50 (n=22)	81.8	68.2	95.4	100	81.8	95.4	90.9	100.0	90.9
50-иас дээш (n=60)	78.3	80.0	100.0	96.7	91.7	100.0	98.3	96.7	91.7

3.5.1 ЭХБАРИХЫНБАНӨХӨНҮРЖИХҮЙНЭРҮҮЛМЭНДИЙНТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЗАРИМ ХЭРЭГСЭЛ ТАСАРСАН ШАЛТГААН

Үнэлгээ хийх үед хамгийн их тасарсан хэрэгсэл нь 24 хэмжээний уян зүү байсан ба 56.5% нь хангамжийн байгууллагаас, 30.4% ҮҮН-ээс хамаарсан бол, уян зүү 18-ын хувьд 58.8% хангамжаас, 35.2% нь ҮҮН-ээс шалтгаалж тус тус тасарсан байлаа.

Амьсгалын маскнаас дутуу нярайн маск хамгийн их тасалдалтай байсан ба тасарсан зонхилох шалтгаанд 46.1% нь хангамжаас, 38.5% нь ҮҮН-ээс, 7.7% нь зах зээлд байхгүй, 7.7% нь бусад шалтгаанаас болж тасарсан байлаа. (Хүснэгт 26)


Хүснэгт 26. Эх барихын ба нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд зайлшгүй шаардлагатай зарим хэрэгслийн тасарсан шалтгаан

Шалтгаан	Уян зүү 24 G (n=23)	Уян зүү 18 G (n=17)	Дуслын систем (n=1)	Амбу (n=4)	Дутуу нярайн амьсгалын маск. (n=13)	Гүйцэд нярайн амьсгалын маск (n=2)	Хүчилтөрөгчийн баллон /өтгөрүүлэгч/ (n=6)	Насанд хүрсэн хүний амьсгалын маск (n=3)	Салиа соруулах гуурс
Хангамжаас шалтгаалсан	56.5	58.8	-	75.0	46.1	-	-	66.7	57.1
ҮҮН-ээс шалтгаалсан	30.4	35.2	100.0	25.0	38.5	100.0	50.0	33.3	14.3
Зах зээлд байхгүй	-	-	-	-	7.7	-	-	-	-
Бусад	13.0	5.9	-	-	7.7	-	50.0	-	28.6

3.5.2 ҮҮН-ийн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга, хэрэгслийн нөөц сүүлийн 6 сард тасарсан байдал

Үнэлгээг гүйцэтгэхээс өмнөх 6 сарын хугацаанд орчин үеийн ЖСАХ-ийн тасалдлын байдлыг эм, хэрэгсэл тус бүрээр судалж үзэхэд хамгийн их тасарсан нь эм

бэлгэвч (89.1%), яаралтай уух эм (71.0%), суулгац (52.1%), тариа (22.9%), эр бэлгэвч ба уух эм (19.0%) тасарчээ.



Зураг 5. Үнэлгээнд хамрагдсан ҮҮН-ийн ЖСАХ сүүлийн 6 сард тасарсан байдал

ЖСАХ “өнгөрсөн 6 сарын дотор тасарсан эсэх”-ийг үнэлэхдээ орчин үеийн ЖСАХ-ийн аль нэг төрөл нь өнгөрсөн 6 сар дотор хамгийн багадаа нэг хоногоор тасарч байсан гэсэн тохиолдолд “тасарсан” хэмээн авч үзсэн.

Хүснэгт 27-д үнэлгээнд хамрагдсан ҮҮН-д өнгөрсөн 6 сарын байдлаар ЖСАХ тасарсан эсэхийг тусламж үйлчилгээний

шатлалаар үзүүлсэн. Бүх ҮҮН-ийн 93.1%-д аль нэг төрлийн ЖСАХ дор хаяж нэг өдрөөр тасарсан байжээ. Үүнийг эмнэлгийн тусламж үзүүлэх шатлалаар нь судалж үзэхэд гурав дах шатлалын ҮҮН-д бүх төрлийн ЖСАХ тасарсан бол, анхан шатанд 96.6% тасарсан бол хоёр дах шатлалын ҮҮН-ийн 78.9%-д тасарчээ. (Хүснэгт 27)

Хүснэгт 27. Өнгөрсөн 6 сард ЖСАХ-ийн тасалдал (ҮҮН-ийн шатлалаар)

ҮҮН-ийн шатлал	ҮҮН-ийн хувь		Дүн
	Өнгөрсөн 6 сард ЖСАХ огт тасраагүй	Өнгөрсөн 6 сард ЖСАХ тасарсан	
Анхан шат	3.4	96.6	161
Хоёр дах шатлал	21.1	78.9	38
Гурав дах шатлал	0.0	100.0	6
Дүн	6.9	93.1	205

ҮҮН-ийн жирэмслэхээс сэргийлэх орчин үеийн арга, хэрэгслийн нөөцийн сүүлийн 6 сарын тасалдлын байдлыг, бүсчлэлээр үнэлж хүснэгт 28-д үзүүлэв.

Улаанбаатар хотын бүх ҮҮН-үүд сүүлийн 6 сард ЖСАХ-ийн хангамж тасарсан бол

зүүн бүсийн ҮҮН-ийн 5.9%, хангайн бүсийн 7.5%, баруун бүсийн 11.1% ба төвийн бүсийн ҮҮН-ийн 16.7%-д ЖСАХ-ийн хангамж тасраагүй гэсэн үзүүлэлттэй гарав. (Хүснэгт 28)

Хүснэгт 28. Сүүлийн 6 сард ЖСАХ-ийн тасарсан байдал, ҮҮН-ийн бүс нутгаар

Бүсчлэлээр	ҮҮН-ийн хувь		Дүн
	Сүүлийн 6 сард ЖСАХ огт тасраагүй	Сүүлийн н 6 сард ЖСАХ тасарсан	
Баруун бүс	11.1	88.9	33
Хангайн бүс	7.5	92.5	42
Төвийн бүс	16.7	83.3	40
Зүүн бүс	5.9	94.1	20
Улаанбаатар	0.0	100.0	70
Дүн	6.9	93.1	205

Үнэлгээ хийхээс өмнөх 6 сард орчин үеийн ЖСАХ тасарсан байдлыг ҮҮН-ийн байршилтай холбож судлахад Улаанбаатар хотод байрласан ҮҮН-ийн нийлүүлэлт бүрэн тасарсан байдал илэрсэн бол хөдөө орон нутгийн эмнэлгүүдийн 10.8% хангамж тасраагүй байжээ. (Хүснэгт 29)

Хүснэгт 29. Сүүлийн 6 сард ЖСАХ-ийн тасалдлын байдал, ҮҮН-ийн байршлаар

Байршил	ҮҮН-ийн хувь		Дүн
	Сүүлийн 6 сард ЖСАХ огт тасраагүй	Сүүлийн 6 сард ЖСАХ тасарсан	
Хот	0.0	100.0	70
Хөдөө	10.8	89.2	135
Дүн	6.9	93.1	205

3.5.3 ҮҮН-ИЙН ЖИРЭМСЛЭХЭЭС СЭРГИЙЛЭХ ОРЧИН ҮЕИЙН АРГА, ХЭРЭГСЛИЙН НӨӨЦ СҮҮЛИЙН 6 САРД ТАСАРСАН ШАЛТГААН

Сүүлийн 6 сард ЖСАХ-ээс эм бэлгэвч хамгийн их буюу 164 тохиолдолд тасарсан байсан ба үүний 66.5% нь хангамжийн байгууллага нийлүүлээгүй хэмээсэн бол 7.3% нь ҮҮН-ээс хамаарсан, 25.0% нь зах зээлд байхгүй, 1.2% нь бусад шалтгаанаар тус тус тасарчээ. Яаралтай уух эм нь 86.0% хангамжаас, 4.9% ҮҮН-ээс, 1.4% зах зээлд байхгүй, 7.7% нь бусад шалтгаанаар тасарсан гэсэн байна. Тарианы хангамжгүй байгаа шалтгааны 89.8% нь хангамжийн байгууллагаас шалтгаалсан бол ҮҮН-ээс шалтгаалж 6.1%, үлдсэн 4.1% нь зах зээлд байхгүйгээс болсон хэмээн хариулжээ.

Суулгацын хувьд нийт тасарсан тохиолдол 48 байсан ба үүний 47.9% хангамжаас, 10.4% нь ҮҮН-ээс, 41.7% нь сургагдсан ажилтан байхгүй шалтгаанаар тасарсан байв. (Хүснэгт 30)

Хүснэгт 30. ҮҮН-д сүүлийн 6 сарын байдлаар ЖСАХ тасарсан шалтгаан

Шалтгаан	ЖСАХ						
	Эр бэлгэвч (n=38)	Эм бэлгэвч (n=164)	Уух эм (n=39)	Тариа (n=49)	Ерэндаг (n=28)	Яаралтай уух эм (n=143)	Суулгац (n=48)
Хангамжаас шалтгаалсан	97.4	66.5	92.3	89.8	67.9	86.0	47.9
ҮҮН-ээс шалтгаалсан	2.6	7.3	7.7	6.1	7.1	4.9	10.4
Зах зээлд байхгүй	-	25.0	-	4.1	-	1.4	-
Сургагдсан ажилтан байхгүй	-	-	-	-	17.9	-	41.7
Бусад	-	1.2	-	-	7.1	7.7	-

3.6 ҮҮН-ИЙН ХАНГАМЖИЙН ТОГТОЛЦОО

Судалгаанд хамрагдсан ҮҮН-үүдэд ЖСАХ, нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийг анхан шатанд 40.4%, хоёр дах шатлалд 36.8%, гурав дах шатлалд 33.3%-д нь эм зүйч нар

хариуцан ажиллаж байна. Эм, хэрэгслийн захиалгыг хийхдээ хэрэгцээн дээр үндэслэдэг хэмээн анхан шатны ҮҮН-ийн 63.3% нь хариулсан бол, хоёр дах шатлалд 71.0%, гурав дах шатлалд 50.0% дээрх хариултыг өгчээ. ЖСАХ, нөхөн үржихүйн эрүүл мэндийн зайлшгүй шаардлагатай эмийн хангамжийн

захиалгыг хийхдээ маягт ашигладаг гэж судалгаанд хамрагдсан ҮҮН-ийн 66.7%-75.9% нь хариулсан. Дийлэнх (88.3%-94.4%) ҮҮН-үүд захиалсан эм, хэрэгслийг өөрсдөө хариуцан татах тогтолцоотой нь байлаа.

Эм, хэрэгсэл нийлүүлэх давтамжийг судалж үзэхэд 50.0%-87.0% нь 3-6 сарын хугацаанд хангамж ирдэг хэмээн хариулжээ. (Хүснэгт 31)

Хүснэгт 31. ҮҮН-ийн эмийн хангамжийн тогтолцооны байдал

Хангамжийн тогтолцоо	Үйлчилгээ үзүүлэх нэгжийн төрөл		
	Анхан шат N=161	Хоёр дах шатлал N=38	Гурав дах шатлал N=6
Эмийн захиалга, хангамжийг хариуцдаг ажилтан			
Эмч	18.6	21.0	33.3
Эх баригч	6.8	26.3	16.7
Эм зүйч	40.4	36.8	33.3
Сувилагч	34.2	15.7	16.7
ЖС эм, хангамжийн захиалгыг хэрхэн хийдэг			
Хэрэгцээнд үндэслэн	63.3	71.0	50.0
Хангамжийн байгууллага	25.5	21.0	33.3
Бусад	11.2	7.8	16.7
Эм, хангамжийн захиалга хийхдээ ямар нэг маягт ашигладаг эсэх			
Тийм (шалгахад байсан)	75.9	70.2	66.7
Тийм (шалгахад байгаагүй)	15.2	16.2	33.3
Үгүй ашигладаггүй	8.9	13.5	0.0
Эм хангамжийн үндсэн эх сурвалж			
Төв эм ханган нийлүүлэх байгууллага	82.6	76.3	66.7
Орон нутгийн эм ханган нийлүүлэх байгууллага	10.6	18.4	33.3
Эмнэлгийн эмийн сан	12.4	0.0	0.0
ТББ			
Донор байгууллага	3.7	5.2	0.0
Хувийн байгууллага	1.9	0.0	0.0
Эм хангамжийг тээвэрлэн авчрах ажлыг хэн хариуцдаг			
Засгийн газар	0.6	0.0	0.0
Орон нутгийн захиргаа	0.6	7.8	0.0
ҮҮН өөрөө	94.4	76.3	83.3
Бусад	4.4	15.7	16.7
Захиалга өгснөөс эм хангамж иртэл дунджаар ямар хугацаа ордог			
<2 долоо хоног	35.6	55.2	50.0
2-4 долоо хоног	12.5	15.7	16.6
1-2 сар	15.0	7.8	16.6
2-4 сар	15.6	7.8	0.0
4-6 сар	13.7	7.8	0.0
6-аас дээш сар	7.5	5.2	16.7
Дунджаар ямар давтамжтай хангалт хийдэг			
2 долоо хоног бүр	4.9	18.4	16.7
Сард 1 удаа	4.9	23.6	16.7
3 сард 1 удаа	36.6	26.3	16.7
6 сард 1 удаа	50.3	23.6	50.0
Жилд 1 удаа	2.4	5.2	
6-аас дээш сар	0.6	2.6	0.0

3.6.1 ҮҮН-ийн хүйтэн хадгалах системийн байдал

Үнэлгээнд хамрагдсан ҮҮН-ийн 71.1%-100.0% нь хүйтэн хадгалах системтэй буюу хөргөгчтэй байсан нь тусгай орчин шаардаж

хадгалдаг эмийг горимын дагуу хадгалах боломжтой байв. (Хүснэгт 32)

Хүснэгт 32. ҮҮН-ийн хүйтэн хадгалах системийн байдал

Хүйтэн хадгалах систем	Үйлчилгээ үзүүлэх нэгжийн шатлал		
	Анхан шат N=161	Хоёр дах шатлал N=3838	Гурав дах шатлал N=6
Хүйтэн хадгалах систем ашигладаг			
Тийм	71.1	73.6	100.0
Үгүй	28.3	26.3	0.0
Магадлах боломжгүй	0.6	0.0	0.0
Хэрэв тийм гэж хариулсан бол ямар хүйтэн хадгалах системтэй вэ?	n=124	n=30	n=6
Хөргөгч	67.7	100.0	100.0
Бусад	32.3	0.0	0.0
Эрчим хүчний нөөц			
Үндсэний цахилгаан сүлжээ	91.3	100.0	100.0
ҮҮН дээр байрлах эх үүсвэр	8.7	0.0	0.0
Дизель үүсгэвэр	0.0	0.0	0.0

Гэр бүл төлөвлөлтийн сургалтанд хамрагдсан байдлыг тодруулахад “сүүлийн 12 сараас дээш хугацаанд ямар нэгэн сургалтанд хамрагдаагүй” гэж анхан шатны ҮҮН-ийн 30.4%, хоёр дах шатлалын ҮҮН-ийн 26.5%, гурав дах шатлалын ҮҮН-ийн 66.7% нь хариулжээ. Сургалтанд хамрагдсан

эмч нар суулгац тавьж үйлчлэхгүй байгаа шалтгааныг “зориулалтын өрөө байхгүй” хэмээн тодорхойлсон ба дээрх хариултыг анхан шатны ҮҮН-үүд 98.8%, хоёр дах шатлалд 97.4% тус тус байжээ. (Хүснэгт 33).

Хүснэгт 33. Судалгаанд хамрагдсан ҮҮН-ийн эмч, ажилчдын гэр бүл төлөвлөлтийн сургалтанд хамрагдсан байдал

Сургалт	Үйлчилгээ үзүүлэх нэгжийн төрөл		
	Анхан шат N=161	Хоёр дах шатлал N=38	Гурав дах шатлал N=6
ГБТ-ийн сургалтанд хамрагдсан эмчийн дундаж тоо	3.9	6.3	5.5
Суулгацын сургалтанд хамрагдсан эмчийн дундаж тоо	1.5	2.5	3.3
Хамгийн сүүлд хэзээ сургалтанд хамрагдсан			
Сүүлийн 1 сард	10.9	17.6	-
Сүүлийн 2-6 сард	29.7	35.2	33.3
Сүүлийн 6-12 сард	25.4	20.5	-
Сүүлийн >12 сард	34.1	26.5	66.7
Сургалтанд суулгац тавих талаар заасан уу			
Тийм	24.4	65.5	83.3
Сургалтанд хамрагдсан эмч нар суулгацаар үйлчилж байгаа юу (n=86)	18.6	86.7	100
Хэрэв сургагдсан ажилтан суулгац тавихгүй байгаа бол шалтгааныг дурьд			
Зориулалтын өрөө байхгүй	98.8	97.4	-
Багаж байхгүй	0.6	-	-
Туршлага байхгүй	0.6	-	-
Суулгац байхгүй	0.0	2.6	-
Бусад	0.0	-	-

Үнэлгээнд хамрагдсан ҮҮН-д дэмжлэгт хяналт сүүлийн 12 сард ирээгүй гэсэн тохиолдол анхан шатанд 23.7%, хоёр болон гурав дах шатлалд 18.4% ба 33.3% тус тус

байсан нь дэмжлэгт хяналтыг төлөвлөгөөтэй зохион байгуулах цаг болсоныг харуулж байна. (Хүснэгт 34)

Хүснэгт 34. ҮҮН-ийн НҮЭМ-ийн үйлчилгээ үзүүлэгч нарын үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийсэн байдал

Хяналт	Үйлчилгээ үзүүлэх нэгжийн төрөл		
	Анхан шат N=220	Хоёр дах шатлал N=38	Гурав дах шатлал N=6
Сүүлийн 12 сарын хугацаанд ГБТ, НҮЭМ-ийн талаар хамгийн сүүлд хэзээ шалгалт ирсэн			
<1 сар	7.7	15.7	-
1-3 сар	9.1	15.7	16.7
3-6 сар	30.5	23.6	16.7
6-12 сар	28.7	26.3	33.3
Сүүлийн жилд ирээгүй	23.7	18.4	33.3
Шалгалтын үед дараах зүйлсийг шалгадаг			
Эмч ажилчдын ажил	65.9	76.3	33.3
Эмийн нөөцийн дуусах хугацаа	65.4	84.2	66.7
Хүний нөөц, сургалт	45.0	55.2	33.3
Ажлын чанар, өвчний түүх бичилт, тайланг хугацаандаа өгдөг эсэх	40.4	55.2	66.6
НҮЭМ-ийн тусламж, үйлчилгээний удирдамж мөрдөж ажилладаг	76.8	86.8	83.3
Бусад	9.5	5.2	16.6

3.6.2 ҮҮН-ийн НҮЭМ-ийн удирдамж, протокол ашиглалт

Шатлал харгалзахгүйгээр дийлэнх ҮҮН-д жирэмсний хяналтын ба гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээний талаарх удирдамж, протоколууд бэлэн байлаа. Гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээнд хэрэглэдэг

шалгах хуудсууд анхан шатанд 32.7%, хоёр дах шатлалын ҮҮН-д 45.9% ба гурав дах шатлалын ҮҮН-д 66.7% хэрэглэгдэж байна. (Хүснэгт 35)

Хүснэгт 35. ҮҮН-ийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн удирдамж, протокол ашиглалт

Удирдамж, протокол	Үйлчилгээ үзүүлэх нэгжийн төрөл		
	Анхан шат N=161	Хоёр дах шатлал N=38	Гурав дах шатлал N=6
Тус ҮҮН ГБТ-ийн үндэсний (ДЭМБ) удирдамж байгаа эсэх?			
Тийм (шалгахад байсан)	79.2	84.2	83.3
Тийм (шалгахад байгаагүй)	11.3	13.2	16.7
Байхгүй	9.4	2.6	0.0
Тус ҮҮН ГБТ-ийн үйлчилгээнд хэрэглэдэг шалгах хуудастай эсэх?			
Тийм (шалгахад байсан)	32.7	45.9	66.7
Тийм (шалгахад байгаагүй)	20.5	16.2	16.7
Байхгүй	46.7	37.8	16.6
Тус ҮҮН жирэмсний хяналтыг хийх үндэсний (ДЭМБ) удирдамжтай эсэх?			
Тийм (шалгахад байсан)	79.2	92.1	100
Тийм (шалгахад байгаагүй)	9.4	5.3	0.0
Байхгүй	11.3	2.6	0.0
Тус ҮҮН жирэмсний хяналтыг хийхэд хэрэглэдэг шалгах хуудастай эсэх ?			
Тийм (шалгахад байсан)	69.6	84.2	66.7
Тийм (шалгахад байгаагүй)	11.3	5.3	33.3
Байхгүй	18.9	10.5	0.0
Тус ҮҮН эмнэлгийн хог хаягдлыг устгах удирдамжтай эсэх ?			
Тийм (шалгахад байсан)	76.4	84.2	33.3
Тийм (шалгахад байгаагүй)	12.7	13.2	66.7
Байхгүй	10.8	2.6	0.0

ҮҮН-ийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн удирдамж, протокол ашиглалтын ялгааг хот, хөдөөгөөр авч үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдсангүй. (Хүснэгт 36)

Хүснэгт 36. ҮҮН-ийн НҮЭМ-ийн удирдамж, протокол ашиглалт (хот, хөдөөгөөр)

Удирдамж, протокол	Үйлчилгээ үзүүлэх нэгжийн төрөл хот хөдөөгөөр	
	Хот N=70	Хөдөө N=135
Тус ҮҮН ГБТ-ийн үндэсний (ДЭМБ) удирдамж байгаа эсэх?		
Тийм (шалгахад байсан)	73.9	83.6
Тийм (шалгахад байгаагүй)	18.8	8.2
Байхгүй	7.2	8.2
Тус ҮҮН ГБТ-ийн үйлчилгээнд хэрэглэдэг шалгах хуудастай эсэх ?		
Тийм (шалгахад байсан)	36.2	31.9
Тийм (шалгахад байгаагүй)	31.9	13.1
Байхгүй	31.9	50.8
Тус ҮҮН жирэмсний хяналтыг хийх үндэсний (ДЭМБ) удирдамжтай эсэх?		
Тийм (шалгахад байсан)	91.3	77.6
Тийм (шалгахад байгаагүй)	2.9	11.2
Байхгүй	5.8	11.2
Тус ҮҮН жирэмсний хяналтыг хийхэд хэрэглэдэг шалгах хуудастай эсэх ?		
Тийм (шалгахад байсан)	78.6	68.9
Тийм (шалгахад байгаагүй)	10.0	11.3
Байхгүй	11.4	19.7
Тус ҮҮН эмнэлгийн хог хаягдлыг устгах удирдамжтай эсэх ?		
Тийм (шалгахад байсан)	76.7	77.3
Тийм (шалгахад байгаагүй)	18.9	9.8
Байхгүй	1.4	12.9

3.6.3 ҮҮН-ийн интернет, мэдээлэл технологийг ашигладаг байдал

Үнэлгээнд хамрагдсан ҮҮН-ийн 95.7% нь орчин үеийн мэдээлэл, технологийн хэрэгслийг ашигладаг ба анхан шатны эмнэлгийн 54.6%, хоёр дах шатлалын ҮҮН-ийн 60.5%, гурав дах шатлалын ҮҮН-ийн 83.3% нь интернетэд холбогдсон гэжээ.

Тэдгээр ҮҮН-ийн компьютер, мэдээллийн хэрэгсэл нь ихэвчлэн байгууллагын өмч бөгөөд дүн бүртгэл, харилцаа холбоо ба эмч, ажилчдын сургалтанд ашигладаг байна. (Хүснэгт 37)

Хүснэгт 37. ҮҮН-ийн интернет, мэдээлэл технологийг ашигладаг байдал

Интернет, мэдээлэл технологи	Үйлчилгээ үзүүлэх нэгжийн төрөл		
	Анхан шат N=161	Хоёр дах шатлал N=38	Гурав дах шатлал N=6
Тус ҮҮН орчин үеийн мэдээлэл, технологийн хэрэгслээс аль нэгийг нь ашигладаг эсэх			
Тийм	95.7	97.4	100.0
Үгүй	4.3	2.6	0.0
Магадлах боломжгүй	0.0	0.0	0.0
Хэрэв тийм бол дараах ИМТ-ийн аль төрлийг ашигладаг болох			
Компьютер	100.0	97.4	100.0
Гар утас	83.8	86.8	100.0
Ухаалаг гар утас	29.1	42.1	66.6
Таблет	1.8	5.3	0.0
Интернет холболт	54.6	60.5	83.3
Wi-Fi	53.4	50.0	50.0
Мэдээлэл, технологийн хэрэгслийн хангамж			
Эмч, ажилчдын хувийн өмч	31.1	28.9	33.3
Засгийн өмч	24.2	47.4	50.0
ҮҮН-ийн өмч	88.8	60.5	100.0
Тусламжаар авсан	13.0	36.8	50.0
Бусад	-	2.6	-
ҮҮН-ийн мэдээллийн хэрэгслийн гол зориулалт, ашиглалт			
Өвчтөн бүртгэх	75.8	63.1	100.0
Дүн бүртгэл	93.1	84.2	100.0
Өвчний түүхийг хөтлөх	16.8	26.3	33.3
ЭМ-ийн даатгал, төлбөр	24.2	52.6	83.3
Мөнгө шилжүүлэх ба төлбөр төлөх	10.5	10.5	33.3
Харилцаа холбоо	66.5	71.0	88.3
Ухуулга сурталчилгаа	83.2	81.6	88.3
Эмийн нөөцийг бүртгэх, хянах	50.9	60.5	66.7
Эмч ажилчдын сургалт	85.1	86.8	83.3
Клиник зөвлөгөө алсын зайнаас (мэргэжилтнээс зөвлөгөө авах)	31.7	52.6	100.0
Бусад	8.7	2.6	-

3.6.4 ҮҮН-ийн үйлчилгээний төлбөр

Судалгаанд хамрагдсан дийлэнх төрийн өмчит ҮҮН-үүд зөвлөгөө өгөх, жирэмслэхээс

сэргийлэх эмийн болон үйлчилгээ үзүүлэхдээ төлбөр авдаггүй гэж хариулсан (Хүснэгт 38).

Хүснэгт 38. ҮҮН үйлчлүүлэгчээс төлбөр авч байгаа байдал (шатлалаар)

Төлбөр хийгддэг байдал	Үйлчилгээ үзүүлэх нэгжийн төрөл		
	Анхан шат N=161	Хоёр дах шатлал N=38	Гурав дах шатлал N=6
Тус ҮҮН ГБТ-ийн зөвлөгөөг төлбөртэй хийдэг эсэх			
Тийм	1.9	0.0	0.0
Үгүй	98.1	100	100
Тус ҮҮН эмийн төлбөр авдаг эсэх			
Тийм	5.0	2.6	0.0
Үгүй	95.0	97.4	100
Тус ҮҮН зарим төрлийн эмнэлгийн үйлчилгээндээ төлбөр авдаг эсэх			
Тийм	3.1	10.5	16.7
Үгүй	96.9	89.5	83.3

Гэр бүл төлөвлөлтийн зөвлөгөөг хотод төлбөртэй үзүүлэх хандлагатай байсан бол хөдөөд эмийн төлбөр авах илүүтэй байгаа

дүр зураг харагдсан ч энэ статистик ач холбогдол бүхий ялгаагүй байлаа. (Хүснэгт 39)

Хүснэгт 39. ҮҮН үйлчлүүлэгчээс төлбөр авч байгаа байдал (хот, хөдөөгөөр)

Төлбөр хийгддэг байдал	Үйлчилгээ үзүүлэх нэгжийн байршил	
	Хот N=70	Хөдөө N=135
Тус ҮҮН ГБТ-ийн зөвлөгөөг төлбөртэй хийдэг эсэх		
Тийм	2.9	0.7
Үгүй	97.1	99.3
Тус ҮҮН эмийн төлбөр авдаг эсэх		
Тийм	2.9	5.2
Үгүй	97.1	94.8
Тус ҮҮН зарим төрлийн эмнэлгийн үйлчилгээндээ төлбөр авдаг эсэх		
Тийм	4.3	5.2
Үгүй	95.7	94.8

3.6.5 Эмнэлгийн хог хаягдал, устгал

Эмнэлгийн хог хаягдлын устгал нь ҮҮН-ийн шатлалаас хамаарч ялгаатай байдал ажиглагдлаа. Бүх шатлалын дийлэнх ҮҮН хог хаягдлаа эмнэлгийн хог хаягдал устгадаг тусгай албаныхнаар, тусгай шатаадаг

зуухыг ашиглан устгадаг хэдий ч ахуйн хог хаягдалтай хамт устгадаг цөөн тооны анхан шатны ҮҮН байгааг тодорхойлов. (Хүснэгт 40)

Хүснэгт 40. ҮҮН-ийн эмнэлгийн хог, хаягдал устгалын байдал (шатлалаар)

Эмнэлгийн хог хаягдал устгал	Эмнэлгийн шатлал		
	Анхан шат N=161	Хоёр дах шатлал N=38	Гурав дах шатлал N=6
Тус ҮҮН эмнэлгийн хог хаягдлаа хэрхэн устгадаг ?			
Эмнэлгийн хашаанд шатаадаг	5.0	0.0	0.0
Эмнэлгийн хашаанд тусгай газар булдаг	3.1	0.0	0.0
Тусгай шатаадаг зуух ашигладаг	34.2	36.8	16.7
Тусгай хариуцсан албаныхан авч яваад устгадаг	57.7	63.2	83.3

Хөдөө байрлах ҮҮН-үүд дийлэнхдээ хог хаягдлаа тусгай шатаадаг зууханд шатааж байгаа бол хотод тусгай хариуцсан албаар устгуулж байна. (Хүснэгт 41)

Хүснэгт 41. ҮҮН-ийн эмнэлгийн хог хаягдал устгалын байдал (хот, хөдөөгөөр)

Эмнэлгийн хог хаягдал устгал	Эмнэлгийн байршил	
	Хот N=70	Хөдөө N=135
Тус ҮҮН эмнэлгийн хог хаягдлаа хэрхэн устгадаг		
Эмнэлгийн хашаанд шатаадаг	0.0	5.9
Эмнэлгийн хашаанд тусгай газар булдаг	0.0	3.7
Тусгай шатаадаг зуух ашигладаг	2.8	50.4
Тусгай хариуцсан албаныхан авч яваад устгадаг	97.1	32.4
Ахуйн хог хаягдалтай цуг хаядаг	0.0	0.1

3.7 Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгаа

Үнэлгээний үед нөхөн үржихүйн эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч байсан 1690 үйлчлүүлэгчээс сэтгэл ханамжийн судалгаа авсан ба 800 нь анхан шатны ҮҮН-ээс, 770 нь хоёр дах шатлалаас хамрагдсан бол гурав дах шатлалаас 120 хүн тус тус хамрагджээ. Насны ангиллаар авч үзэхэд 19-өөс доош насны үйлчлүүлэгч анхан шатны 0.7%, хоёр дах шатлалд 1.0% буюу маш цөөн байсан. 1998, 2003 онуудад хийгдсэн нөхөн үржихүйн эрүүл мэндийн судалгаагаар ЖСАХ-ийн хэрэглээ 15-19 насанд хамгийн бага байсан үр дүнтэй дүйцэж, түүвэрлэлт алдаа бага байгааг харуулж байна. Түүнчлэн 40-өөс дээш насанд бусад насны бүлгээс харьцангуй бага байгаа нь ажиглагдлаа. Эрэгтэйчүүд гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээ авахаар

эмнэлэгт хандах нь ховор байна. Зонхилох үйлчлүүлэгчид нь гэрлэсэн, дунд болон түүнээс дээш боловсролтой эмэгтэйчүүд байлаа. (Хүснэгт 42)

Хүснэгт 42. Үйлчлүүлэгчдийн талаарх ерөнхий мэдээлэл (шатлалаар)

Ерөнхий мэдээлэл	Үйлчилгээ үзүүлэх нэгжийн төрөл		
	Анхан шат N=800	Хоёр дах шатлал N=770	Гурав дах шатлал N=120
Насны ангилал			
19-өөс доош нас	0.7	1.0	0.0
20-24 нас	9.2	12.8	9.1
25-29 нас	33.3	31.9	31.6
30-34 нас	21.2	20.6	19.1
35-39 нас	16.7	17.6	25.0
40-49 нас	18.6	15.8	15.0
Хүйс			
Эрэгтэй	1.0	1.4	0.8
Эмэгтэй	99.0	98.6	99.2
Гэрлэлтийн байдал			
Гэрлээгүй	7.0	9.1	4.1
Гэрлэсэн	91.3	90.3	94.1
Салсан	1.6	0.5	1.6
Боловсролын түвшин			
Боловсролгүй	0.6	1.1	1.6
Бага	2.7	3.2	5.8
Дунд, түүнээс дээш	96.6	95.5	92.5
ГБТ-ийн үйлчилгээ авахаар та ҮҮН-д ханддаг тоо			
Сард 1 удаа	30.8	24.8	15.0
2 сард 1 удаа	5.9	4.8	2.5
Сар бүр	45.3	32.7	35.0
Бусад	17.8	37.6	47.5

Үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийг үйлчилгээ үзүүлэгчийн харьцаа, зөвлөгөө өгч байгаа чадвар зэрэг асуултаар үнэлсэн. Анхан шатны эмнэлгээр үйлчлүүлсэн эмэгтэйчүүд хоёр болон гурав дах шатлалын ҮҮН-тэй харьцуулахад сэтгэл ханамж илүү байв. Үйлчилгээ авахын тулд удаан хүлээсэн эсэхийг асуухад гурав дах шатлалд 30.0% нь, хоёр дах шатлалд 23% нь, анхан шатны эмнэлэгт 14.8% нь үйлчилгээ авахын тулд удаан хугацаагаар хүлээсэн гэж хариулсан нь дээд шатлалын эмнэлэг илүү ачаалалтай ажилладагтай холбоотой байж болох юм. (Хүснэгт 43)

Хүснэгт 43. ҮҮН-ээс гэр бүл төлөвлөлтийн үйлчилгээ авч байгаа үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн байдал

Асуумж	Үйлчилгээ үзүүлэх нэгжийн төрөл		
	Анхан шат N=800	Хоёр дах шатлал N=770	Гурав дах шатлал N=120
Үйлчлүүлэгчийн хандлага			
Та хүссэн үйлчилгээгээ авч чадсан уу ?	97.1	93.5	90.8
Таны хүссэн үйлчилгээг үзүүлэхдээ таны хүслийг харгалзан үзсэн үү ?	95.3	92.4	96.6
Эмч ажилтан тухайн аргыг хэрхэн хэрэглэх талаар танд зааж зөвлөсөн үү?	93.8	90.6	90.0
